



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

2020



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

2015-2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль болон  
мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид  
(панел судалгааны дөрөв дэх жилийн үр дүн)

Судалгааг гүйцэтгэсэн:Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,  
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Б.Батбаатар	ХНХСИ-ийн захирал
М.Алтансүх	ХНХСИ-ийн дэд захирал
С.Батхолбоо	ХЭБСС-ын эрхлэгч
Д.Алтангэрэл	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Г.Мягмардуулам	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Н.Жаргалсайхан	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
С.Хүрэл-Эрдэнэ	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Ш.Дэлгэрхишиг	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М.Энхзориг	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Ундрям	Гадаад харилцааны мэргэжилтэн

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний ерөнхий газар,  
5 давхар

Утас: 77121286

Вэб хуудас: [www.rilsp.gov.mn](http://www.rilsp.gov.mn)

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	v
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	vi
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	vii
ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ.....	.ix
СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ.....	x
<b>БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>1</b>
1.1. Судалгааны үндэслэл .....	2
1.2. Судалгааны зорилго .....	2
1.3. Судалгааны түүврийн дизайн .....	2
1.4. Судалгааны зохион байгуулалт .....	7
1.4.1. Асуулгын хуудасны бүтэц .....	7
1.4.2. Мэдээлэл цуглувалт, боловсруулалт .....	7
1.5. Ойлголт, тодорхойлолт .....	7
<b>БҮЛЭГ 2. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>11</b>
2.1. Төгсөгчдийн хүн ам зүйн төлөв байдал.....	12
2.2. Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл, сэтгэл ханамж.....	13
2.3. Төгсөгчдийн дахин суралцаж буй сургалт.....	16
<b>БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧДИЙН 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТӨЛӨВ .....</b>	<b>19</b>
3.1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв .....	20
3.2. Төгсөгчдийн ажилгүйдэл, ажил хайх үйл явц.....	33
3.3. Ажиллах хүчинээс гадуурх төгсөгчид /Эдийн засгийн идэвхгүй байдал/ .....	36
3.4. Төгсөгчдийн ажлын туршлага, цаашдын төлөвлөгөө .....	38
<b>БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН.....</b>	<b>43</b>
4.1. Төгсөгчдийн 4 жилийн эдийн засгийн идэвх.....	44
4.2. Дөрвөн жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн төлөв .....	45
4.3. 2017 ба 2019 оноос хойш эдийн засгийн идэвхийн шилжилт хийсэн байдал .....	48
<b>БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧДИЙН 2017, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН .....</b>	<b>53</b>
5.1. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт.....	54
5.2. 2017 онд ажилтай байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт .....	57
5.3. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт .....	60
5.4. 2017, 2020 онд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны төлөв, өөрчлөлт .....	62
<b>БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН .....</b>	<b>69</b>
6.1. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт.....	70
6.2. 2019 онд ажилтай байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт .....	72

6.3. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт .....	76
6.4. Сүүлийн хоёр жилийн хугацаанд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд гарсан өөрчлөлт .....	78
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>83</b>
<b>САНАЛ ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>86</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>88</b>

## ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгааны 2020 оны тайлан хүрч байна. Энэ удаагийн судалгаанд 2015/2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийг дөрөв дэх жилдээ хамрууллаа. Ингэснээр “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны 2 дахь модуль амжилттай хэрэгжиж дуусч байгаа юм.

Судалгааны зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршдог.

Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг ажил мэргэжлийн түвшинд нь судлах нь бодлого боловсруулахад үр дүнтэй. Өөрөөр хэлбэл төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлтийг хянах, ажилгүйдлийн шалтгааныг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлд буй ажлын байрны шаардлагад боловсрол сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа мэргэжилтний ур чадвар нийцэж байгаа эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, тэдний бодит байдал, хэтийн төлөвлөгөө зэрэг асуудлуудыг тоон болон чанарын үзүүлэлтүүдээр тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой.

Энэ удаагийн судалгааны тайлан нь ХЗЗ дэх 2020 оны төлөв, төгсөгчдийн 4 жилийн хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг харьцуулснаараа онцлог боллоо.

Та бүхэн судалгааны дүн, тайлантай танилцсан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, шинжилгээтэй холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

ЗАХИРАЛ

Б.БАТБААТАР



# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл .....	2
Хүснэгт 2. Судалгааны мэдээллийн хамралт, алдааны хязгаар.....	3
Хүснэгт 3. ИДС төгсөгчдийн түүврийн хэмжээ, Дээд мэргэжлийн чиглэлээр.....	4
Хүснэгт 4. МБСБ төгсөгчдийн түүврийн хэмжээ, мэргэжлийн чиглэлээр.....	5
Хүснэгт 5. Мэдээлэл цуглуулалт, сургалтын төрлөөр .....	5
Хүснэгт 6. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр .....	21
Хүснэгт 7. Эрхэлж буй ажил болон эзэмшсэн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр .....	23
Хүснэгт 8. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажлын дундаж хугацаа, сарын дундаж цалин орлого, сургуулийн төрлөөр .....	25
Хүснэгт 9. Төгсөгчдийн сарын дундаж цалин, орлого, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр .....	27
Хүснэгт 10. Гэрээтэй хөдөлмөр эрхэлж буй эсэх, ЭЗҮА-ны салбараар .....	28
Хүснэгт 11. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн даатгал, татварын үзүүлэлт .....	29
Хүснэгт 12. Ажлын байрны сэтигэл ханамжийн үнэлгээ, сургуулийн төрлөөр .....	31
Хүснэгт 13. Ажлын байран дахь ерөнхий ур чадварын хомсдол, сургуулийн төрлөөр .....	32
Хүснэгт 14. Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг хүчин зүйл, сургуулийн төрлөөр .....	35
Хүснэгт 15. Хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, ЭЗҮА-ны салбар, хувиар .....	41
Хүснэгт 16. 4 жилийн эдийн засгийн идэвх, сургуулийн төрлөөр .....	44
Хүснэгт 17. 4 жилийн эдийн засгийн идэвх, хүйсээр .....	45
Хүснэгт 18. 2017 оноос хойш ЭЗ-ийн идэвхэд шилжилт хийсэн байдал, хүйсээр .....	48
Хүснэгт 19. 2019 оноос хойш ЭЗ-ийн идэвхийн шилжилт, шинж байдлаар, хувиар .....	50
Хүснэгт 20. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн цэвэр ба бохир үзүүлэлтүүд, 2017, 2019 он, сургуулийн төрлөөр .....	54
Хүснэгт 21. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр .....	55
Хүснэгт 22. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн цэвэр ба бохир үзүүлэлтүүд, 2017, 2020 он, хүйсээр .....	56
Хүснэгт 23. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар .....	57
Хүснэгт 24. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ажиллаж байсан байгууллагын өмчийн хэлбэрээр .....	58
Хүснэгт 25. 2017 онд ажиллаж байсан салбар нь 2020 онд өөрчлөгдсөн эсэх, төгсөгчдийн зарим үзүүлэлтээр .....	63
Хүснэгт 26. 2017, 2020 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар .....	67
Хүснэгт 27. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвх, 2019, 2020 он, сургуулийн төрлөөр .....	70
Хүснэгт 28. Эдийн засгийн идэвхэд шилжилт хийсэн байдал, сургуулийн төрлөөр .....	71
Хүснэгт 29. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн шилжилт, 2019, 2020 он, хүйсээр .....	72

Хүснэгт 30. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар.....	73
Хүснэгт 31. 2019, 2020 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар .....	82

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төгсөгчдийн насын бүлэг, сургуулийн төрлөөр .....	12
Зураг 2. Төгсөгчдийн үндсэн захиргаа, амьдарч буй байршилаар .....	13
Зураг 3. ИДС төгсөгчид мэргэжлийн чиглэлээр .....	13
Зураг 4. МБСБ төгсөгчид мэргэжлийн чиглэлээр .....	14
Зураг 5. Цаашид сайжруулах шаардлагатай зүйлс, сургуулийн төрлөөр .....	15
Зураг 6. Суралцах хугацаандаа илүү эзэмших шаардлагатай байсан гэж үзсэн мэдлэг, чадвар, сургуулийн төрлөөр .....	16
Зураг 7. Дахин суралцагчдын сургалтын төрөл .....	16
Зураг 8. Дахин суралцаж буй шалтгаан .....	17
Зураг 9. Эзэмшсэн болон одоо суралцаж буй мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр .....	17
Зураг 10. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр .....	20
Зураг 11. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр .....	22
Зураг 12. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр .....	22
Зураг 13. ИДС төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт .....	23
Зураг 14. МБСБ төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт .....	24
Зураг 15. Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллахгүй зонхилох шалтгаан, сургуулийн төрлөөр .....	25
Зураг 16. Хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр .....	26
Зураг 17. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр .....	27
Зураг 18. Эзэмшсэн боловсрол, АБ-нд шаардагдах боловсролын түвшний нийцэл .....	29
Зураг 19. АБ-нд шаардагдах ур чадвар, эзэмшсэн ур чадварын нийцэл .....	30
Зураг 20. Ур чадвараа эзэмшсэн байдал, сургуулийн төрлөөр .....	30
Зураг 21. Суралцах хугацаандаа олж авсан ур чадварын хэрэглээ, ашиглалт .....	31
Зураг 22. Ажлын байран дахь мэргэжлийн мэдлэг, ур чадварын хомсдол, сургуулийн төрөлд эзлэх хувь .....	33
Зураг 23. Ажилгүй байгаа ИДС төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр .....	34
Зураг 24. Ажилгүй байгаа МБСБ төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр .....	34
Зураг 25. Төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгаан, сургалтын төрлөөр .....	35
Зураг 26. Боломжит ажиллах хүч, сургалтын төрөл, бүсээр .....	36
Зураг 27. Ажил хийгээгүй болон дахин суралцаагүй залуучууд .....	37
Зураг 28. Ажиллаж байсан байгууллага, ажлаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлс .....	38
Зураг 29. Ажиллаж байсан ажлын чиг үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцэл .....	38
Зураг 30. Цаашид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар санал, хүсэлт .....	39
Зураг 31. Цар тахлын нөлөө .....	40
Зураг 32. Хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр .....	40
Зураг 33. Ажлын байр хайх, ажилд ороход цар тахал нөлөөлсөн эсэх .....	42

Зураг 34. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн ИДС төгсөгчид, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр .....	46
Зураг 35. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн МБСБ төгсөгчид, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр .....	46
Зураг 36. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн төгсөгчид, ЭЗҮА-ны салбараар .....	47
Зураг 37. 2017 оноос хойш ЭЗИ-д шилжилт хийсэн байдал, ИДС-н мэргэжлийн чиглэлээр .....	49
Зураг 38. 2017 оноос хойш ЭЗИ-д шилжилт хийсэн байдал, МБСБ-н мэргэжлийн чиглэлээр .....	49
Зураг 39. 2019 оноос хойш ЭЗИ-ийн шилжилт, МБСБ-ийн мэргэжлийн чиглэлээр.....	51
Зураг 40. 2019 оноос хойш ЭЗИ-ийн шилжилт, ИДС-н мэргэжлийн чиглэлээр ....	52
Зураг 41. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хувиар .....	57
Зураг 42. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байсан эсэхээр .....	59
Зураг 43. 2017 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах боловсролын түвшний шаардлагын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэхээр.....	59
Зураг 44. 2017 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах ур чадварын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэх .....	60
Зураг 45. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, сургуулийн төрлөөр .....	60
Зураг 46. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, хүйсээр.....	60
Зураг 47. 2017 онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт .....	61
Зураг 48. 2017 онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт.....	62
Зураг 49. 2017 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх .....	62
Зураг 50. 2017 онд ажиллаж байсан салбараа 2019 онд өөрчилсөн эсэх, ЭЗҮА-ны салбараар.....	64
Зураг 51. 2017 оноос цалин, орлого нь өөрчлөгдсөн байдал, сургуулийн төрөл, хувиар .....	64
Зураг 52. Мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэх байдалд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр .....	65
Зураг 53. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2017, 2020 онд гарсан өөрчлөлт, ИДС-н мэргэжлийн чиглэлээр .....	66
Зураг 54. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2017, 2019 онд гарсан өөрчлөлт, МБСБ-ын мэргэжлийн чиглэл, хувиар .....	67
Зураг 55. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хувиар .....	73
Зураг 56. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байсан эсэхээр.....	74
Зураг 57. 2019 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах боловсролын түвшний шаардлагын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэхээр .....	75
Зураг 58. 2019 оны хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшсэн ба ажлын байранд шаардах	

ур чадварын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэх.....	75
Зураг 59. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, сургалтын төрлөөр.....	76
Зураг 60. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, амьдарч байсан байршлаар .....	76
Зураг 61. 2019 онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр.....	77
Зураг 62. 2019 онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр .....	78
Зураг 63. 2019 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх.....	78
Зураг 64. 2019 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх, ЭЗҮА-ны салбараар.....	79
Зураг 65. 2019 оноос хойш цалин, орлого нь өөрчлөгдсөн байдал, сургуулийн төрөл, хувиар .....	80
Зураг 66. Мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр .....	80
Зураг 67. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2019, 2020 онд гарсан өөрчлөлт, ИДС-ийн мэргэжлийн чиглэлээр.....	81
Зураг 68. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2019-2020 онд гарсан өөрчлөлт, МБСБ-ын мэргэжлийн чиглэлээр .....	82
Зураг 69. 2018, 2019 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар .....	82

## ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АБ	Ажлын байр
АХГ	Ажиллах хүчинээс гадуурх
ИДС	Их, дээд сургууль
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБОС	Мэргэжлийн боловсрол олгох сургалт
ТБОС	Техникийн боловсрол олгох сургалт
ОУБ	Олон улсын байгууллага
ХАА	Хөдөө, аж ахуй
ХЭДБ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ЭЗИ	Эдийн засгийн идэвх
CV	Curriculum vitae /Товч намтар/
TOEIC	Test of English for International Communication
TOEFL	Test of English as a Foreign Language

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны зорилго нь их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй бэрхшээл, ажилгүй байгаа шалтгаан зэргийг бодитойгоор илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршино

Судалгаанд 2015/2016 оны хичээлийн жилд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш бакалаврын боловсрол эзэмшин, төгссөн 44.9 мянган төгсөгчдийг төлөөлүүлэн 4909 төгсөгчдийг сонгон 2017 оны судалгаанд хамруулж 4 жил мөшгөн судалсан юм. 2020 онд дээрх төгсөгчдийн 3671 төгсөгчдөөс нь мэдээлэл цуглуулав. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу гадаад явсан, нас барсан, холбоо барих хэрэгсэл нь өөрчлөгдсөн, татгалзсан зэрэг шалтгаанаар эхний жилийн түүврээс хасагдav. Судалгааны эх олонлогийн хувьд 61.5 хувь буюу 27.6 мянга нь их, дээд сургуулийг өдрийн бакалаврын анги, 38.5 хувь буюу 17.3 мянга нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид байна.

Энэ удаагийн судалгааны тайлан нь төгсөгчдийн мэргэжил эзэмшсэнээс хойш 48 сарын хугацааг агуулсан. Уг судалгаанд Х33 дэх 2020 оны төлөв, төгсөгчдийн 4 жилийн /2017/2020, 2019/2020 он/ хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг харьцуулснаараа онцлог боллоо.

2020 онд төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж, 4.5 хувь нь ажилгүй, 20.7 хувь нь ажиллах хүчинээс гадуурх /хуучнаар эдийн засгийн идэвхгүй/ төгсөгчид байна

Төгсөгчдийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын буюу ажилгүй төгсөгчид болон боломжит ажиллах хүчиний нэгдсэн түвшинг тооцож үзэхэд нийт төгсөгчдийн 13.7 хувьд нь хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байна. Ажиллах хүчинээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй байгаа төгсөгчдийн 40.4 хувь нь цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боломжит ажиллах хүч байна.

Нийт боломжит ажиллах хүчиний 4.1 хувь нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байгаа, ур чадварт тохирох ажил байхгүй, туршлага байхгүй, ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу гэж үздэгийн улмаас итгэл алдарсан байна.

Нийт төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 48.8 хувь нь эрэгтэйчүүд, 51.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургалтын төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 76.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 71.5 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ЭЗҮА-ны салбараар авч үзвэл 11.9 хувь нь боловсролын, 11.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.6 хувь нь үйлчилгээний, 9.2 хувь нь барилгын, 8.3 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 7.5 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн хalamжийн үйл ажиллагаа салбарт ажиллаж байна.

Төгсөгчид ажил олгогчтой гэрээ байгуулж ажиллах нь ажлын байр баталгаатай байх үндэс болох ба хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 85.6 хувь нь ямар нэг гэрээ байгуулан ажиллаж байна. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 90.3 хувь нь МБСБ төгсөгчдийн 76.7 хувь нь ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан байна. МБСБ төгсөгчдийн 23.3 хувь нь гэрээгүй ажиллаж байгаа нь өмнөх оноос 7.6 пунктээр буурсан байна.

Төгсөгчид хөдөлмөр эрхэлж байгаа нь чухал хэдий ч сургуульд суралцаж эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг тандан, судлах хэрэгтэй юм. Тодорхой цаг хугацаа, хөрөнгө зарцуулан эзэмшсэн мэргэжилтэйгээ тохиорхгүй өөр чиглэлийн ажил хийх байдал МБСБ төгссөн хоёр төгсөгч тутмын нэгд нь, ИДС төгссөн арван төгсөгч тутмын гуравд тохиолдож байгаа нь анхаарахгүй орхиж болохгүй үзүүлэлт юм.

Төгссөнөөс хойш 4 жилийн дараах байдлаар ИДС төгсөгчдийн 76.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 66.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөд эзлэх мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлтийг ИДС-ийн мэргэжлийн чиглэлээр тодруулбал анагаах ухаан, мал эмнэлэг, багш боловсрол судалын мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй таван төгсөгч тутмын дөрөв нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Харин ХАА, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, хүмүүнлэгийн ухаан, нийгмийн халамж, хангамж зэрэг мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт хамгийн бага буюу мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөр байна.

МБСБ төгсөгчдөөс анагаах ухаан, эрчим хүч, үйлчилгээний мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 67.5-83.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байгаа бол боловсрол, мэдээллийн технологи, байгаль орчин, аялал жуулчлал, ХАА-н мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй 5 төгсөгч тутмын 3 нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байна. Эдгэрээс харахад МБСБ төгсөн хөдөлмөр эрхэлж буй 2 төгсөгч тутмын 1 нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгааг сургалтын болон бодлого боловсруулж буй байгууллага анхаарах хэрэгтэй. Хөдөлмөрийн зах зээлийн шингээлт багатай мэргэжлээр элсэлт авч байгаа эсэх, тухайн ажлын байранд ур чадварын зөрүү гарч байгаа эсэхэд, мэргэжил сонголтын алдаа байгаа эсэхийг нарийвчлан судалж, анхаарал хандуулах хэрэгтэй.

Хөдөлмөр эрхэлж байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад тухайн эзэмшсэн мэргэжлийн ажлын байр хомс, олдохгүй байгаа, цалин бага, мэргэжлээрээ ажиллах сонирхол байхгүй, ажилласан жилийн туршлага шаарддаг учраас, одоо ажиллаж буй ажилдаа сэтгэл ханамжтай, өөрийнхөө сонирхлоороо ажиллаж байгаа, хувийн болон гэр булийн бизнес эрхэлж байгаа зэрэг шалтгаан түлхүү байна.

Мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй, мэргэжилдээ сэтгэл ханамжгүй, өөр мэргэжлээр ажиллаж байгаа ч тухайн ажилдаа сэтгэл ханамжтай байгаа төгсөгчдөөс харахад нийт төгсөгчдийн 10 гаруй хувьд нь мэргэжил сонголтын алдаа байгаа нь харагдаж байгаа юм.

Зарим төгсөгчид өөрийн эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшинг ажлын байрны шаардлагаас доогуур гэж үнэлсэн нь ажилтан, ажил олгогчийн шаардлагад тэнцэхгүй байдал ажлын байранд байгаа нь хувь хүчин зүйлстэй холбоотой байж болох хэдий ч мэргэжлийн боловсрол олгож буй сургалтын байгууллагуудын боловсон хүчин бэлтгэх байдлын чанарыг харуулах нэг хэмжүүр байж болох талтай.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид 4 жилийн хугацаанд хамгийн ихээр нэрлэсэн ерөнхий ур чадварын дутагдал нь багаар ажиллах, харилцааны, бие даан ажиллах, шийдвэр гаргах зэрэг чадварууд байна. Тухайн ур чадваруудыг дээд болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагад сургах гэхээсээ илүүтэй бага, дунд шатны боловсрол олгох байгууллагаас нь эзэмшүүлж эхлэх хэрэгтэй

юм. Ажиллаж буй ажлын байранд дутагдаж буй мэргэжлийн ур чадваруудыг тодруулахад нийт төгсөгчдөд гадаад хэл, компьютерын мэдлэг, баримт бичиг боловсруулах, мэргэжлийн мэдлэг, чадвар илүү дутагджээ.

Судалгааны 4 жилийн хугацаанд хамгийн ихээр дутагдаж буй мэдлэгийн нэг бол гадаад хэл буюу англи хэлний мэдлэг байна. Зарлагдаж буй шинэ, сүл ажлын байранд хэлний мэдлэгтэй байх нь ажил горилогчийн нэг давуу тал болж байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Цаашид төрөөс хөдөлмөр эрхлэхэд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар тодруулахад 15.9 хувь нь дэмжлэг туслалцаа хэрэггүй гэжээ. Харин 13.9 хувь нь цалин нэмэх, илүү цагийн цалинг тооцох, 12.7 хувь нь ажлын байр нэмэгдүүлэх, 6.6 хувь нь зээлийн хүүг бууруулах, төсөл хөтөлбөрийн зээлд хамрагдах, 6.5 хувь нь сургалтад хамруулах, ажлын байрны дадлагажуулах сургалтууд, 5.0 хувь нь мэргэжлийн, тогтвортой ажлын байраар хангахад түлхүү анхаарах шаардлагатай байгаа талаар саналаа хэлсэн байна.

Сургалтын хөтөлбөр болон сургалтын байгууллагын цаашид сайжруулах шаардлагатай зонхилох саналыг төгсөгчдийн 44.1 хувь нь дадлагын ажлыг чанаржуулах, хугацааг уртасгаж, байгууллагатай холбож өгөх, 17.1 хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн, сурх бичиг, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, номын сан, анти танхимиын хүрэлцээг нэмэгдүүлэх, 12.7 хувь нь сургалтын агуулга, хөтөлбөр, чанарыг сайжруулах, 11.3 хувь нь багшийн заах арга зүй, харилцаа, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг хүчин зүйлсийг түлхүү нэрлэсэн байна. Үүнээс харахад ИДС, МБСБ-үүд цаашид сайжруулах, анхаарах шаардлагатай зүйлүүд бол дадлагын чанар, хүртээмж, сургалтын хэрэглэгдэхүүн болох ном сурх бичиг, тоног төхөөрөмж гэх мэт материаллаг бааз болох нь харагдаж байна. Сургуулиудын сургалтын хөтөлбөр, материаллаг баазаа шинэчилж байж хурдтай хувьсан өөрчлөгдөж буй техник, технологийн хувьсгал түүнд тохирсон, нийцэх ажлын байранд тэнцэх боловсон хүчинийг бэлтгэж чадах юм.

Сурч байх хугацаандаа юу илүү сурх байж гэж бодож байгаа тухайд ИДС төгсөгчдийн 32.9 хувь нь гадаад хэл сурх, 26.2 хувь нь дадлага, шинжилгээ сайн хийж, практик дээр илүү туршлага хуримтлуулах, 8.3 хувь нь мэргэжлээ дээшлүүлж, гүнзгийрүүлж судлах, сайн сурх, 6.1 хувь нь мэргэжлийн болон компьютерын хэрэглээний программыг илүү судлах гэсэн бол МБСБ төгсөгчдийн 20.9 хувь нь мэргэжлээ дээшлүүлж, гүнзгийрүүлж судлах, сайн сурх, 18.3 хувь нь дадлага, шинжилгээ сайн хийж, практик дээр илүү туршлага хуримтлуулах, 18.0 хувь нь гадаад хэл сурх гэсэн байна. Мөн ИДС төгсөгсдийн 2.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 4.7 хувь нь мэргэжил сонголтдоо сэтгэл ханамжгүй байна.

Корона вируст /covid-19/ цар тахал төгсөгчдөд хэрхэн нөлөөлж буй талаар хэдэн асуултуудаар дамжуулан судлахыг зорилоо. Энэхүү судалгааны мэдээлэл цуглуулалт 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд явагдсан болно. Энэ байдал дотоодод халдвартархсан 2020 оны 11 дүгээр сараас хойш өөрчлөгдсөн байж болно.

Нийт төгсөгчдийн 45.7 хувь нь корона вируст /covid-19/ цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, өрхийн орлого, цалин хэлс гэх мэт хүчин зүйлсэд өөрчлөлт гараягүй гэжээ. Харин төгсөгчдийн 22.4 хувь нь цалин, орлого буурсан, санхүүгийн хүндрэл үүссэн, 7.6 хувь нь сургууль, цэцэрлэг ажиллахгүйгээс болж хүүхэд харах хүнгүй ажил хийх боломжгүй болсон зэрэг нь дийлэнх хувийг эзэлж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөд корона вируст цар тахал хэрхэн нөлөөлж буй талаар тодруулахад 24.8 хувь нь өрхийн орлого буурсан, 22.9 хувь нь ажлын цаг багассан, 19.3 хувь нь цалин буурсан, 13.0 хувь нь борлуулалтын орлого буурсан зэрэг зонхилох өөрчлөлт гарчээ.

Боловсролын салбарт ажиллаж байгаа төгсөгчдийн 36.4 хувь нь ажлын цаг багассан, 24.0 хувь нь цалин буурсан гэсэн бол ХАА-н салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 37.5 хувь нь өрхийн болон бизнесийн орлого буурсан, 20.7 хувь нь борлуулалтын орлого буурчээ.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 43.2 хувь нь цалингүй чөлөө олгосон, 44.0 хувь нь ажлын цаг багассан гэсэн бол удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй 5 төгсөгч тутмын 4 нь цалин буурсан нөлөө үзүүлсэн байна.

Ажилгүй болон эдийн засгийн идэвхгүй байгаа төгсөгчдийн 56.6 хувьд нь цар тахлын нөлөө байгаагүй байна. Харин 10.5 хувь нь ажлын байр багассан, цомхотгол хийсэн, 7.8 хувь нь ажил олдоогүй, ажилд ороход хүндрэлтэй байна, 6.2 хувь нь хөл хорионд орсон, хөл хорионос болж ажил хийх, ажил хайх боломжгүй байгаа, 5.6 хувь нь ажил зогссон, сүл зогсолт хийсэн зэрэг түлхүү шалгаан хэлжээ.

Энэ удаагийн тайланда сургуулиа төгссөнөөс хойш дөрвөн жилийн хугацаанд төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг судалсан. Ингэхэд хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 45.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 38.5 хувь нь 2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээрийг эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу хөдөлмөр эрхэлж байгаа эсэхийг тодруулахад ИДС төгсөгчдийн 74.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 55.3 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна.

2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 85.7 хувь нь гэрээ байгуулан ажиллаж байна. Тэдгээрийг ажиллаж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь харахад салбар бүрт 80 ба түүнээс дээш хувь нь гэрээтэй буюу онцлон ялгарах салбар харагдаагүй.

2017, 2020 оны судалгааны үр дүнг харьцуулахад төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 13.9 хувиар өссөн, ажилгүйдлийн түвшин 11.8 хувиар буурсан мэт боловч бодит хөдөлмөрийн зах зээлд энэ дүнгээс илүү хэмжээний эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хөдөлгөөнүүд төгсөгчдийн дунд гарсан. Тухайлбал, нийт төгсөгчдийн 86.8 хувь нь 2017, 2020 онд ямар нэгэн байдлаар ажил эрхэлсэн байгаа ба тэдний зарим нь судалгаа авах 2 жилд хоёуланд ажилтай байсан, зарим нь аль нэг жилд нь л ажиллаж бусад үед нь ажилгүй юм уу эдийн засгийн идэвхгүй төлөвт байсан байна.

2017 онд хөдөлмөр эрхэлж байсан 5 төгсөгч тутмын 4 нь хөдөлмөр эрхэлсэн, ажилгүй байсан төгсөгчдийн 6.7 хувь нь ажилгүй хэвээрээ, ЭЗИ-гүй байсан төгсөгчдийн 30.6 хувь нь төлөвөө өөрчлөөгүй байна.

ИДС төгсөгчдийн 4 жилийн хугацаанд эзэмшсэн мэргэжлээрээ болон тогтвортой хөдөлмөр эрхэлж буй нь барилга, архитектур, мал эмнэлэг, тээвэр, анааах ухаан, урлаг, физик, хими, геологи, газар зүй зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчид буюу 10 төгсөгч тутмын 7-9 нь байна. Харин хөдөлмөр эрхлэлт хамгийн бага, мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөртэй нь хүмүүнлэгийн ухаан, нийгмийн халамж, хангамж, байгаль хамгаалал, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, ХАА-н мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байна

МБСБ төгсөгчдийн хувьд эрүүл мэнд, эрчим хүч, барилга, уул уурхай, тээвэр, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид сүүлийн 4

жилийн хугацаанд бусадтайгаа харьцуулахад илүү эзэмшсэн мэргэжлээрээ болон тогтвортой хөдөлмөр эрхэлсэн байна. Харин ХАА, боловсрол, байгаль орчин, аялал жуулчлал, мэдээллийн технологи мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт тогтвортгүй, мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөртэй байна.

2017, 2020 онд хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн 44.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлсэн хэвээрээ, 29.7 хувь нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 17.9 хувь нь мэргэжлийн ажлаас мэргэжлийн бус ажил руу шилжсэн байна. Харин ИДС төгсөгчдийн 58.9 хувь нь мэргэжлийн ажил хийсэн хэвээр байгаа бол 15.7 хувь нь мэргэжлийн бус ажил хийдэг хэвээр, 13.3 хувь нь мэргэжлийн бус ажил руу шилжжээ.

Харин сүүлийн 2 жилд ИДС төгсөгчдийн 63.0 мэргэжлээрээ ажилласан хэвээрээ, 32.0 хувь нь мэргэжлийн бус ажил хийдэг хэвээрээ болон мэргэжлийн бус ажил руу шилжин ажиллаж байна. МБСБ төгсөгчдийн 47.2 хувь нь мэргэжлийн ажил хийдэг хэвээрээ, 23.7 хувь нь ажил мэргэжил тохирдоггүй хэвээрээ, 22.0 хувь нь мэргэжлийн ажлаас мэргэжлийн бус ажил руу шилжсэн байна.

2017, 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 80 гаруй хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээрээ байгаа ч тухайн салбартай тогтвортой ажиллаж чадаагүй байна. 2017, 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан 10 төгсөгч тутмын 4-5 нь ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбараа өөрчилжээ.

2017, 2020 оны цалингийн өөрчлөлтийг харьцуулан харахад ИДС төгсөгчдийн 4.2 хувь нь цалин буурсан, 83.6 хувь нь цалин өссөн, 12.2 хувь нь цалин буурсан гэсэн бол, МБСБ төгсөгчдийн 9.9 хувь нь цалин хэвээрээ, 76.4 хувь нь цалин өссөн, 13.7 хувь нь цалин буурсан гэжээ. Харин сүүлийн 2 жилийн хувьд төгсөгчдийн 57.5 хувь нь цалин өссөн, 15.9 хувь нь цалин хэвээр, 26.6 хувь нь цалин буурсан байна.

2017, 2019 онд гэрээтэй хөдөлмөр эрхэлж байсан 10 төгсөгч тутмын 9 нь гэрээтэй ажилласан хэвээрээ байна. Харин 2017 онд гэрээгүй ажиллаж байсан төгсөгчдийн 26.3 хувь нь 2019 онд гэрээгүй ажиллаж байсан төгсөгчдийн 44.0 хувь гэрээгүй ажилласан хэвээрээ байна.

2017 онд ажилгүй байсан 3 төгсөгч тутмын 2 нь, 2019 онд ажилгүй байсан 10 төгсөгч тутмын 4 нь 2020 онд хөдөлмөр эрхэлж байна. Харин тухайн хоёр онд ажилгүй байсан эмэгтэй төгсөгчдийн 30 гаруй хувь нь ЭЗИ-гүй байна.

Харин эдийн засгийн идэвх нь хамгийн их өөрчлөлт, хөдөлгөөнтэй нь баруун бүсэд амьдарч буй төгсөгчид байна.

I

БҮЛЭГ  
**СУДАЛГААНЫ  
ТАНИЛЦУУЛГА**

## 1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг нийгмийн тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэсэн хэлбэрээр зохион байгуулахаар холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд туссан байдаг. Тухайлбал, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын:

- 1.3.5-д хөдөлмөрийн зах зээлд сүүлийн жилүүдэд дээд боловсролтой ажиллах хүчний тоо нэмэгдсэн боловч ажиллах хүчний ур чадвар доогуур байгаа нь ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүйд хүрч, мэргэшсэн ажиллах хүчний дутагдлыг бий болгож байна;
- 1.3.6-д ажилгүйдлийн түвшин хөдөлмөрийн насын залуучуудын дунд ихсэж байгаа тул залуучуудад буюу их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдөд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэжээ.

Тиймээс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн багц асуудлыг тодорхойлох төрөлжсөн судалгаануудыг хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай юм. Ялангуяа хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн томоохон бүлэг болох их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн судалгааг тогтмол хийх нь чухал ач холбогдолтой.

## 1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ХЗЗ дэх өөрчлөлт, хөдөлгөөн, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй бэрхшээл болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг бодитойгоор илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдлага, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршино.

## 1.3. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ДИЗАЙН

Түүврийн эх олонлог, хүрээ: 2015-2016 оны хичээлийн жилд Монгол Улсын их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн нийт төгсөгчид нь түүврийн эх олонлогийг бүрдүүлнэ. (Магистр, доктор, орой, эчнээ ангийн сургалтад хамрагдсан болон цэрэг, цагдаа, аюулгүй байдал, батлан хамгаалахын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид эх олонлогт багтахгүй)

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл

2015-2016 оны хичээлийн жил	Тоо	Түүврийн хэмжээ
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо	81	81
Их, дээд сургуулийн тоо	105	105
Нийт	186	186
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо	17442	2265
Их, дээд сургууль төгсөгчдийн тоо	25906	2781
Нийт	43348	5046

Судалгаанд их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох байгууллагын 2015-2016 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийн жагсаалтаар

Түүврийн хүрээг бүрдүүлэв. Түүврийн дизайныг боловсруулахад судалгааны зорилгын хүрээнд үр дүнг гаргах домэйн нь мэргэжлийн чиглэл байхыг түүвэрт түгээмэл шаарддаг. Иймээс түүврийн хүрээнд мэргэжлийн чиглэлийг 1 үзүүлэлт болгон, дээд боловсрол олгох сургалтын хүрээнд 22, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтын хүрээнд 13 мэргэжлийн чиглэлийг оруулсан юм. Түүврийн хүрээг бүрдүүлэхэд БСШУСЯ, мэргэжлийн боловсролын байгууллагуудтай хамтран ажиллав.

Түүврийн хэмжээ: Түүврийн дизайныг боловсруулахад өмнөх судалгаанаас илүү боловсронгуй болгох боломж мэдээллийн хувьд бүрдсэн юм. Түүврийн бүлэглэлийг мэргэжлийн чиглэлээр зохиомжлохдоо дээд, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох байгууллагаар ялгасан. Учир нь МБОС-ын байгууллагын төгсөгчдийн тоо ТБОС-ын байгууллагаас хавьгүй илүү байсан бөгөөд түүврийн сонголтод техникийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн төлөөлөл бага сонгогдооор байсан.

Аливаа давтан судалгааг зохион байгуулж буй тохиолдолд үр дүнг харьцуулагдах байдлыг хадгалах нь нэн чухал байдаг. Энэ байдлыг хадгалах нэг гол шинж нь түүврийн дизайн бөгөөд дизайны ерөнхий зарчмыг хадгалах явдал юм. Олон улсын жишигт давтамжтай хийгддэг судалгааны түүврийн дизайныг анхны удаад ижил төстэй судалгааны, давтан хийхдээ өмнөх судалгааны мэдээллийн баазаас түүврийн үнэлгээ хийх замаар тогтоодог. Энэ удаагийн судалгааны түүврийн хэмжээг тооцохдоо дээд боловсролын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувийн жинг түлхүүр үзүүлэлт болгон 2012-2013 оны төгсөгчдийн судалгааны түүврийн алдаанд суурилан тооцоолов.

#### Хүснэгт 2. Судалгааны мэдээллийн хамралт, алдааны хязгаар

Д/д	Мэргэжлийн нэр	Тооцоологдсон үр дүн			Алдааны хязгаар
		Хөдөлмөр эрхтэйт	Стандарт алдаа	Судалгаанд хамрагдсан тоо	
1	Багш, боловсрол судалал	69.4%	6.7%	49	9.6%
2	Үрлаг	69.6%	6.9%	46	9.9%
3	Хүмүүнлэгийн ухаан	63.0%	6.6%	54	10.5%
4	Нийгэм, эдийн засаг	55.3%	7.3%	47	13.3%
5	Мэдээлэл, сэтгүүл зүй	70.0%	7.3%	40	10.5%
6	Бизнес, удирдлага	74.4%	7.1%	39	9.5%
7	Хууль, эрх зүй	57.8%	7.4%	45	12.9%
8	Биологи	66.7%	6.9%	48	10.3%
9	Физик, хими, геологи, газар зүй	73.6%	6.1%	53	8.3%
10	Математик статистик	72.3%	6.6%	47	9.1%
11	Компьютер	80.4%	5.6%	51	7.0%
12	Бүх төрлийн инженер	79.2%	5.9%	48	7.5%
13	Үйлдвэрлэлийн технологи	58.8%	8.6%	34	14.6%
14	Барилга, архитектур	64.3%	7.5%	42	11.6%
15	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй	55.0%	8.0%	40	14.5%
16	Мал эмнэлэг	57.1%	7.1%	49	12.5%
17	Анагаах ухаан	73.8%	6.9%	42	9.3%
18	Нийгмийн хalamж, хангамж	63.0%	7.2%	46	11.4%
19	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	63.0%	9.5%	27	15.0%
20	Тээвэр	77.8%	8.2%	27	10.5%
21	Байгаль хамгаалал	77.3%	6.4%	44	8.3%

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг мэргэжлийн чиглэлээр тооцож үзэхэд алдааны хязгаар хамгийн их нь 15 хувь байна. Тус судалгаа нь 4 жилийн турш панел хэлбэрээр явагдсан бөгөөд дээрх алдааны хязгаар нь судалгааны эцсийн үр дүнд хүлээж байгаатай ойролцоо байсан. Панел судалгааны онцлог нь судлагдаж буй нэгж(төгсөгч)-ийг судалгааны бүх үе шатанд хамруулан мэдээллийг бүрэн авах шаардлагатай байдаг. Нөгөө талаар практикт хүн ам зүй, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалж түүвэрт сонгогдсон нэгжийг бүгдийг хайж олох боломжгүй тул хорогдлын хэмжээг тооцоолох шаардлагатай юм. Тиймээс урд нь хийгдсэн 2 судалгааны жил бүрийн мэдээлэл цуглувалтын хамралтын түвшинд үндэслэн түүврийн хэмжээг өсгөв.

### Хүснэгт 3. ИДС төгсөгчдийн түүврийн хэмжээ, Дээд мэргэжлийн чиглэлээр

Д/д	Мэргэжлийн нэр	Тооцоолгдсон үр дүн		Түүврийн хэмжээ	Хүлээгдэж буй алдааны хязгаар
		Хөдөлмөр эрхлэлт	Стандарт алдаа		
1	Багш, боловсрол судлал	69.4%	6.7%	135	5.8%
2	Үрлаг	69.6%	6.9%	135	5.8%
3	Хүмүүнлэгийн ухаан	63.0%	6.6%	135	6.7%
4	Нийгэм, эдийн засаг	55.3%	7.3%	135	7.8%
5	Мэдээлэл, сэтгүүл зүй	70.0%	7.3%	135	5.7%
6	Бизнес удирдлага	74.4%	7.1%	135	5.1%
7	Хууль, эрх зүй	57.8%	7.4%	135	7.4%
8	Биологи	66.7%	6.9%	135	6.2%
9	Физик, хими, геологи, газар зүй	73.6%	6.1%	135	5.2%
10	Математик, статистик	72.3%	6.6%	81	6.9%
11	Компьютер	80.4%	5.6%	135	4.3%
12	Бүх төрлийн инженер	79.2%	5.9%	135	4.5%
13	Үйлдвэрлэлийн технологи	58.8%	8.6%	135	7.3%
14	Барилга, архитектур	64.3%	7.5%	135	6.5%
15	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй	55.0%	8.0%	135	7.9%
16	Мал эмнэлэг	57.1%	7.1%	135	7.5%
17	Анагаах ухаан	73.8%	6.9%	135	5.2%
18	Нийгмийн халамж, хангамж	63.0%	7.2%	135	6.7%
19	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	63.0%	9.5%	135	6.7%
20	Тээвэр	77.8%	8.2%	135	4.7%
21	Байгаль хамгаалал	77.3%	6.4%	135	4.7%
<b>Бүгд</b>				<b>2781</b>	

Судалгааны хуваарилалтыг хийхдээ олон тооны домэйн /мэргэжлийн чиглэл-/үүдүүн харьцуулагдах байдлыг хангах үүднээс тэгш хуваарилалтын зарчмаар хийсэн болно. МБСБ төгсөгчдийн түүврийн дизайныг хийхдээ ерөнхийдөө ИДС-ын төгсөгчдийн түүврийн дизайныг удирдлага болгосон. Гэхдээ ТБОС-ын төгсөгчдийн тоо харьцангуй цөөхөн байсан тул б мэргэжлийн чиглэлээс бусдад нь нэлэнхийгээр буюу бүх төгсөгчдийг сонгосон юм.

## Хүснэгт 4. МБСБ төгсөгчдийн түүврийн хэмжээ, мэргэжлийн чиглэлээр

Д/д	Мэргэжлийн нэр	МБОС	ТБОС
1	Барилгын салбар	135	80
2	Хөдөө аж ахуйн салбар	135	72
3	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	135	30
4	Тээврийн салбар	135	80
5	Мэдээллийн технологийн салбар	135	55
6	Аж үйлдвэрийн салбар	139	80
7	Уул уурхайн салбар	135	80
8	Үйлчилгээний салбар	135	58
9	Соёл, урлагийн салбар	135	64
10	Эрүүл мэндийн салбар	10	135
11	Санхүү, бизнес, худалдааны салбар	135	37
12	Эрчим хүчний салбар	61	31
13	Боловсролын салбар	21	17
<b>Бүгд</b>		<b>1446</b>	<b>819</b>

Ийнхүү судалгааны нийт түүврийн хэмжээ 5046 төгсөгч болж, 2017 онд эхний жилийн судалгааг зохион байгуулсан. Панел судалгааны хувьд судалгаанд хамрагдсан иргэд хариулахгүй байх болон олдохгүй байх тохиолдол ихээхэн гардаг. Эхний жилийн судалгаанд 4909 төгсөгч хамрагдсан бол 2018 онд 4261 төгсөгч хамрагдаж эхний жилээс 13.2 хувийн хорогдол, 2019 онд 3980 төгсөгч хамрагдаж 18.9 хувийн хорогдол, 2020 онд 3671 төгсөгч хамрагдаж 25.2 хувийн хорогдол гарсан.

## Хүснэгт 5. Мэдээлэл цуглуулалт, сургалтын төрлөөр

Сургалтын төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он
Их дээд сургууль төгсөгч	2754	2437	2223	2067
МБСБ төгсөгч	2155	1824	1757	1604
<b>Бүгд</b>	<b>4909</b>	<b>4261</b>	<b>3980</b>	<b>3671</b>

**Судалгааны нэгжийн сонголт**

Судалгаанд хамрагдах төгсөгчдийг сонгоходоо энгийн санамсаргүй аргыг ашигласан болно. Судалгааны түүврийн хүрээнээс судалгаанд хамрагдах төгсөгчдийг сонгосон техникийг товч тайлбарлай. Юуны өмнө мэргэжлийн чиглэл бүрээр бэлтгэсэн жагсаалт дахь мэдээллийг шалгаж үнэн бодит байдлыг хангаж түүвэр хийхэд бэлдсэний дараа оролцогчдын түүвэрлэлтийг системт санамсаргүй техникийн дагуу гүйцэтгэв.

1. Мэргэжилийн чиглэл бүрийн төгсөгчдийн жагсаалтыг хүйс, оршин суугаа байршилаар эрэмбэлсэн.
2. Эрэмбэлсний дагуу 1-ээс эхлэн дэс дараалуулан дугаарлана. (1-ээс M<sub>hi</sub> хүртэл)

3. Мэргэжилийн чиглэл бүрийн төгсөгчдийн тоо  $M_{hi}$ -г түүврийн хэмжээ  $m_{hi}$ -нд харьцуулж алхам (интервал)  $I_{hi}$ -ыг олно. Энэ харьцааны утгыг бутархайн 2 оронгийн нарийвчлалтай авсан.
4. 0.01 ба  $I_{hi}$ -ийн хооронд бутархайн 2 оронгийн нарийвчлалтайгаар санамсаргүй утга олж жагсаалт бүрээс түүвэрлэгдэх төгсөгчдийг (дугаараар) дараах томьёоны дагуу олсон.

$$S_{hij} = R_{hi} + [I_{hi} \times (j - 1)], \text{ энд } j = 1, 2, 3, \dots, m_{hi}$$

Сонгогдсон төгсөгчийн дугаар  $j$  нь  $Sh_{ij}$ -ийн утгатайгаа тэнцүү байна. Хүйсээр эрэмбэлсний дагуу мэргэжлийн чиглэл бүрд сонгогдсон төгсөгчид хүйсийн хувьд пропорциональ байдаг.

Судалгааны эхний жилийн түүврийн жинг түүврийн дизайны жин болон судалгааны мэдээлэл цуглуулалтын түвшний үржвэрээр тооцсон. Түүврийн дизайны жин нь мэргэжлийн чиглэл бүр дэх нэгжийн сонгогдох магадлалын эсрэг урвуугаар илэрхийлэгддэг.

Тиймээс түүврийн дизайны жин нь:

$$W_{design} = \frac{M_{hi}}{n_{hi}}$$

Энд:  $W_{design}$  = түүврийн дизайны жин (суурь)

$M_{hi}$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх i хүйсийн төгсөгчдийн тоо

$n_{hi}$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх i хүйсийн түүврийн хэмжээ

Судалгааны мэдээлэл цуглуулалтын түвшин 95.5 хувь болсон бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгогдсон төгсөгчдийг олох, холбоо барих боломжгүй тохиолдол гарсан юм. Тиймээс түүврийн хэмжээг хүрээнд нийцүүлэх үүднээс засварлалт хийсэн. Үүнийг түүврийн хариулаагүй түвшний засварлалт гэдэг.

$$W_{nonresponse} = \frac{n_h}{n'_h}$$

Энд:

$n_h$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх i хүйсийн түүврийн хэмжээ

$n'_h$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх судалгаанд хамрагдсан i хүйсийн төгсөгчдийн тоо

Ийнхүү түүврийн жинг тооцоход дээр 2 жингийн үржвэрээр тооцсон.

Түүврийн хүрээг бүрдүүлэхэд холбогдох яам, тухайн сургуулиутай хамтран ажилласан хэдий ч цөөн тооны төгсөгчдийн мэдээллийг бүрэн авч чадаагүй. Өөрөөр хэлбэл түүврийн хүрээ эх олонлогийн хэмжээнээс дутуу байсан тул түүврийн жинг эх олонлогт тохируулан засварласан. Статистикт үүнийг Calibration weight adjustment гэж нэрлэдэг.

$$W_{calibration} = \frac{N_h}{N'_h}$$

Энд:

$N_h$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх эх олонлогийн хэмжээ

$N'_h$  =  $h$  мэргэжлийн чиглэл дэх тархаасан олонлогийн хэмжээ

Судалгааны эцсийн жин нь  $W_{2017} = W_{design} \times W_{nonresponse} \times W_{calibration}$  болсон.

Судалгааны дөрөв дэх жилийн түүврийн жинг тооцоходоо эхний жилийн түүврийн жинг 2 дахь жилийн мэдээлэл цуглуулалтын түвшнээр засварлаж тооцов. Мэдээлэл цуглуулалтын түвшний фактор коэффициент нь:

$W_{nonresponse} = nh_{hi} / n'_h$  бөгөөд эцсийн жин

$$W_{2020} = W_{2019} \times W_{nonresponse} \quad W_{nonresponse} = \frac{n_{hi}}{n'_h} \text{ бөгөөд эцсийн жин}$$

$$W_{2020} = W_{2019} \times W_{nonresponse} \text{ ЮМ.}$$

## 1.4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.4.1. АСУУЛГЫН ХУУДАСНЫ БҮТЭЦ

Судалгааны асуулга нь 7 бүлэг бүхий 148 асуултаас бүрдсэн. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээг харгалзан панел судалгааны арга зүйгээр мэдээллийг цуглуулахаар төлөвлөж, бэлтгэлийг хангахын зэрэгцээ асуулгыг үүнд нийцүүлэн боловсруулсан. Үүнд:

- 1-р бүлэгт Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл/хүнам зүйн мэдээлэл/
- 2-р бүлэгт Одоогийн суралцаж буй сургалтын талаарх мэдээлэл
- 3-р бүлэгт Эдийн засгийн идэвх
- 4-р бүлэгт Одоогийн эрхэлж буй ажил
- 5-р бүлэгт Ажлын туршлага
- 6-р бүлэгт Ажил хайх үйл явц
- 7-р бүлэгт Төлөвлөгөө

### 1.4.2. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг тусгайлан зориулсан аппликашнтай таблет ашиглан ярилцлага авах (CAPI) аргаар гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийг оруулахад CSPro 7.3 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг, судалгааны мэдээллийг боловсруулж, үндсэн үр дүнг нэгтгэн гаргахад SPSS 25 программыг ашигласан болно.

## 1.5. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Судалгаанд их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын /хуучин нэрээр/ "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай" 2010 оны 235 дугаар тушаалаар батлагдан мөрдөгдөж буй дээд боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн ерөнхий чиглэлийг баримталсан. Их, дээд сургууль төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийг 22 мэргэжлийн чиглэлд нэгтгэн авч үзсэн.

Судалгаанд МБСБ төгсөгчдийн мэргэжлийн чиглэлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай" 2016 оны 150 дугаар тушаалаар батлагдан мөрдөж буй мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексийг баримталсан. МБСБ төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийг 13/16 мэргэжлийн чиглэлд нэгтгэн авч үзсэн.

Судалгаанд ажил, мэргэжлийн мэдээлэлд "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08", эдийн засгийн үйл ажиллагааны салбарын мэдээлэлд Сангийн сайдын 2011 оны 103 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг тус тус мөрдлөг болгосон.

Тайланд дурдагдаж буй нэр томьёо, тооцооллыг дараах байдлаар ойлгоно.

**Төгсөгч:** 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багц цагийг ханган, төгсөлтийн шалгалтад тэнцэн, бакалаврын диплом, мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн үнэмлэх авсан төгсөгч, иргэнийг хэлнэ.

**Хөдөлмөрийн насны хүн ам** гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчинээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажиллах хүч** гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

**Ажиллах хүчинээс гадуурх төгсөгчид** гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаarahгүй хөдөлмөрийн насын төгсөгчдийг ойлгоно. Ажиллах хүчинээс гадуурх төгсөгчдөөс боломжит ажиллах хүчин-ийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгднэ.

**Ажилгүй төгсөгч** гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насын төгсөгчид юм.

- a. **хөдөлмөр эрхлээгүй** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаarahгүй байхыг;
- b. **ажил хийхэд бэлэн** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;
- c. **ажил хайж байгаа** гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн төгсөгч юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно.

**Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй төгсөгч юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- a. **Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч** буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа төгсөгч;
- b. **Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн** буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа төгсөгч.

**Итгэл алдарсан ажил хайгч** гэж ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой байгаа хүн амаас хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу мэргэжил, туршилага байхгүйгээс тохирох ажлын байр олж авч чадахгүй байгаагаас эсвэл хэтэрхий залуу гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгаагаас ажлын байр хайж олох найдвараа алдан, ажил хайгаагүй байгаа төгсөгч юм.

**Үрт хугацаагаар ажилгүй байгаа хүн** гэж 12 сар, түүнээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд ажил хайж байгаа болон ажил хийх боломжтой байгаа ажилгүй төгсөгч юм.

**Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа төгсөгчид** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх

шатны сургалтад хамрагдаагүй байгаа ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудыг ойлгоно.

**Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй төгсөгчид:** Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан нь тодорхойлогдох ажиллагч болон ажилгүй иргэдийг хамруулна.

**Эдийн засгийн идэвхгүй төгсөгчид:** Сүүлийн долоо хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй алинд ч хамаarahгүй хүн амыг хамруулна.

**Суралцагч:** Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд дээд боловсролын болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын байгууллагад дахин суралцаж байгаа төгсөгчийг хэлнэ.

**Хөдөлмөр эрхлэлтийн хувь:** Нийт төгсөгчдөд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн эзлэх хувийн жингээр илэрхийлэгдэнэ.

**Хөдөлмөр эрхлэлтийн бохир түвшин:** Панел судалгааны хугацаанд аль нэгэнд, эсвэл бүх хугацаанд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн нийт төгсөгчид эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

**Ажилгүйдлийн бохир түвшин:** Панел судалгааны хугацаанд аль нэгэнд, эсвэл бүх хугацаанд ажилгүй байсан төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

**Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн бохир түвшин:** Панел судалгааны хугацаанд аль нэгэнд, эсвэл бүх хугацаанд нь эдийн засгийн идэвхгүй байсан төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

**Ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон нийт төгсөгчдийн хувь:** Эдийн засгийн идэвхийн төлөв нь өөрчлөгдсөн төгсөгчдийн хувь (ажилтай байснаа ажлаас гарсан +шинээр ажилд орсон гм).

**Ажлын ур чадварын шаардлага, эзэмшсэн ур чадвартай нийцэх түвшин:** Эрхэлж буй ажлын ур чадварын шаардлага, эзэмшсэн ур чадвартай “нийцтэй” гэж үзсэн үнэлгээний утга:

- ✓ Нийцлийн түвшнийг “ажлын ур чадварын шаардлагын түвшин хэт доогуур –1”, “ажлын ур чадварын шаардлагын түвшин доогуур-2”, “ажлын ур чадварын шаардлагын түвшин тохиромжтой – 3”, “ажлын ур чадварын шаардлагын түвшин өндөр-4”, “ажлын ур чадварын шаардлагын түвшин хэт өндөр- 5” гэсэн таван түвшнээр хэмжсэн.

**Ажиллаж буй ажлын байрны боловсролын түвшний шаардлага, эзэмшсэн боловсролтой нийцэх түвшин:** Ажиллаж буй ажлын байрны боловсролын түвшний шаардлага, эзэмшсэн боловсролтой “нийцтэй” гэж үзсэн үнэлгээний утга:

- ✓ Нийцлийн түвшнийг “АБ-ны боловсролын түвшний шаардлага хэт доогуур-1”, “АБ-ны боловсролын түвшний шаардлага доогуур-2”, “АБ-ны боловсролын түвшний шаардлага тохиромжтой-3”, “АБ-ны боловсролын түвшний шаардлага өндөр-4”, “АБ-ны боловсролын түвшний шаардлага хэт өндөр-5” гэсэн таван түвшнээр хэмжсэн.

**Мэргэжил, ажил үүргийн нийцлийн түвшин:** Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг буюу ажил мэргэжил нь эзэмшсэн мэргэжилтэй “тохирдог” гэж үзсэн үнэлгээний утга:

- ✓ “Ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй огт тохиромжгүй-1”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй тийм ч тохиромжтой биш-2”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй тохиромжтой-3”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй маш тохиромжтой-4” гэсэн дөрвөн түвшнээр хэмжсэн.

**Сарын дундаж цалин, орлого:** Цалин хөлстэй ажилтны хувьд цалингаар, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчийн хувьд орлогоор илэрхийлэгдэнэ. Нийт төгсөгчдийн сарын цалин, орлогын арифметик дунджаар тооцсон утга болно.

**7 хоногийн ажлын дундаж цаг:** Ажил хийж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын цагийн арифметик дунджаар илэрхийлэгдэнэ.

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг нийт төгсөгчдийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид}}{\text{Нийт төгсөгчид}} \times 100$$

**Ажилгүйдлийн түвшин:** Ажилгүй төгсөгчдийн тоог нийт төгсөгчдийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Ажилгүй төгсөгчдийн тоо}}{\text{Нийт төгсөгчид}} \times 100$$

**Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчиний нэгдсэн түвшин:** Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг нийт төгсөгчдийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин} = \frac{\text{Ажилгүй төгсөгчид} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Нийт төгсөгчид}} \times 100$$

**Урт хугацааны ажилгүйдлийн түвшин:** Урт хугацаагаар ажилгүй байгаа хүний тоог ажиллах хүчиний тоонд харьцуулж тооцно.

$$\text{Урт хугацааны ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Урт хугацаагаар ажилгүй байгаа төсөгчдийн тоо}}{\text{Нийт төсөгчид}} \times 100$$

**Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа төгсөгчид:** Тухайн хугацаанд суралцаагүй байгаа ажилгүй төгсөгч болон ажиллах хүчинээс гадуурх төгсөгчдийн тооны нийлбэр

Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа төгсөгчид = (Ажилгүй төгсөгчид + Ажиллах хүчинээс гадуурх төгсөгчид) – (Боловсрол сургалтад хамрагдаж байгаа ажилгүйтөгсөгчид+Боловсролсургалтадхамрагдажбайгааажиллаххүчинээсгадуурх залуучууд)

III

БҮЛЭГ  
**ЕРӨНХИЙ  
МЭДЭЭЛЭЛ**

## 2.1 ТӨГСӨГЧДИЙН ХҮН АМ ЗҮЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Судалгаанд 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш, бакалаврын боловсрол эзэмшин төгссөн 44.9 мянган төгсөгчдийг төлөөлүүлэн 4909 төгсөгчдийг сонгон 2017 оноос эхлэн судалгаанд хамруулсан бөгөөд 2020 онд гадаад явсан, нас барсан, холбоо барих хэрэгсэл нь өөрчлөгдсөн, татгалзсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар эхний жилийн түүврээс хасагдаж 3671 төгсөгчийг дөрөв дэх жилийн судалгаанд хамрууллаа.

Судалгааны эх олонлогийн 61.6 хувь буюу 27.5 мянга нь ИДС-ийг өдрийн бакалаврын, 38.4 хувь буюу 17.2 мянга нь МБСБ-ыг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид байсан. Төгсөгчдийн 42.1 хувь нь эрэгтэй, 57.9 хувь нь эмэгтэй бол сургуулийн төрлөөр хараад ИДС төгсөгчдийн 64.8 хувь, МБСБ төгсөгчдийн 47.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанд оролцогчдын дундаж нас 26 бөгөөд энэ үзүүлэлт ИДС төгсөгчдийн хувьд 27 МБСБ төгсөгчдийн хувьд 25 байгаа юм. Мөн тэдгээрийн 26.2 хувь нь 24 хүртэлх насын, 52.4 хувь нь 25-27 насын, 21.4 хувь нь 28 ба түүнээс дээш насын төгсөгчид байна. Сургуулийн төрлөөр дараах зурагт харуулав.

Зураг 1. Төгсөгчдийн насын бүлэг, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж. хувь



Гэрлэлтийн байдлын хувьд төгсөгчдийн 45.3 хувь нь гэрлээгүй, 33.0 хувь нь гэр бүлээ батлуулсан, 21.2 хувь нь гэрлэсэн боловч батлуулаагүй гэжээ. Ам бүлийн тоог бүлэглэн үзвэл 44.8 хувь нь 3 хүртэл, 27.8 хувь нь 4, 27.4 хувь нь 5 ба түүнээс олон ам бүлтэй өрхөд амьдарч байгаа ба ам бүлийн дундаж тоо 4 байна.

ИДС төгсөгчдийн 32.0 хувь нь, МБСБ төгсөгчдийн 49.8 хувь нь эцэг, эхтэйгээ хамт амьдарч байна. Насны хувьд 58.9 хувь нь 24 хүртэлх насын төгсөгчид байгаа юм. Мөн гэрлээгүй төгсөгчдийн 63.9 хувь нь, салсан, туусгаарласан төгсөгчдийн 61.2 хувь нь, гэрлэсэн батлуулаагүй төгсөгчдийн 23.8 хувь нь, гэрлэлтээ батлуулсан төгсөгчдийн 14.0 хувь нь эцэг эхтэйгээ хамт амьдардаг байна.

Зураг 2. Төгсөгчдийн үндсэн захиргаа, амьдарч буй байршлаар  
Хэмжих нэгж: хувь



Төгсөгчдийн үндсэн захиргаа, амьдарч буй байршлыг тодруулахад Улаанбаатарт оршин суугаа төгсөгчдийн 25.4 хувь нь орон нутгийн харьялалтай, орон нутагт оршин суугаа төгсөгчдийн 3.0 хувь нь Улаанбаатарын харьят төгсөгч байна. Энэ нь орон нутагт ажлын байр бага байдагтай холбоотой байж болно.


Төгсөгчдийн өрхийн сарын дундаж орлого 1565.4 мянган төгрөг байгаа бөгөөд ИДС төгсөгчдийнх 1711.7 мянга, МБСБ төгсөгчдийн хувьд 1330.0 мянган төгрөг байна.

## 2.2 ТӨГСӨГЧДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, СЭТГЭЛ ХАНАМЖ

2015-2016 оны хичээлийн жилд ИДС төгсөгчдийн 24.8 хувь нь бизнес, удирдлага, 15.6 хувь нь багш, боловсрол судлал, 10.3 хувь нь анагаах ухаан, 9.5 хувь нь бүх төрлийн инженерийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна. Хувийн өмчийн ИДС-ийн бараг хоёр төгсөгч тутмын нэг нь бизнес, удирдлагын мэргэжлээр төгссөн байна.

Зураг 3. ИДС төгсөгчид мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж.хувь



Мэргэжил боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн дийлэнх хувийг аж үйлдвэрийн (26.9 хувь), барилгын (25.2 хувь), тээврийн (10.9 хувь), уул уурхайн салбарын (8.5 хувь) мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байна.

## Зураг 4. МБСБ төгсөгчид мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь




Төгсөгчид сургалтын хөтөлбөр, сургалтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах тухай өгсөн саналуудыг нэгтгэн дараах зурагт харууллаа. Нийт төгсөгчдийн 44.1 хувь нь дадлагын ажлыг чанаржуулах, хугацааг уртасгаж, байгууллагатай холбож өгөх, 17.1 хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн, сурх бичиг, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, номын сан, анги танхимиын хүрэлцээг нэмэгдүүлэх, 12.7 хувь нь сургалтын агуулга, хөтөлбөр, чанарыг сайжруулах, 11.3 хувь нь багшийн заах арга зүй, харилцаа, мэдлэг, ур чадварыг сайжруулах саналыг өгчээ. Тэдгээрийг сургуулийн төрлөөр ангилан харахад ИДС төгсөгчдийн 46.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 40.3 хувь нь дадлагын ажлыг чанаржуулах, хугацааг уртасгаж, байгууллагатай холбож өгөх хэрэгтэй гэж үзжээ. Үүнээс харахад ИДС, МБСБ-үүд цаашид дадлагын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн болон ном сурх бичиг, тоног төхөөрөмж зэргээ сайжруулах, анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

Сургуулиуд хурдтай хувьсан өөрчлөгдж буй техник, технологийн эринд сургалтын хөтөлбөр, материаллаг баазаа мөн хурдаар шинэчилж байж ажлын байрны шаардлагад нийцэх боловсон хүчнийг бэлтгэж чадах билээ.

Зураг 5. Цаашид сайжруулах шаардлагатай зүйлс, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь




Суралцах хугацаандаа ямар мэдлэг, чадварыг илүү эзэмших ёстай байсан тухай тодруулахад ИДС төгсөгчдийн 32.9 хувь нь гадаад хэл сурх, 26.2 хувь нь дадлага, шинжилгээ сайн хийж, практик дээр илүү туршлага хуримтлуулах, 8.3 хувь нь мэргэжлээ дээшлүүлж, гүнзгийрүүлэн судлах, сайн сурх, 6.1 хувь нь мэргэжлийн болон компьютерын хэрэглээний программыг илүү судлах гэсэн бол МБСБ төгсөгчдийн 20.9 хувь нь мэргэжлээ дээшлүүлж, гүнзгийрүүлж судлах, сайн сурх, 18.3 хувь нь дадлага, шинжилгээ сайн хийж, практик дээр илүү туршлага хуримтлуулах, 18.0 хувь нь гадаад хэл сурх, 5.8 хувь нь мэргэжлийн болон компьютерын хэрэглээний программыг илүү судлах байсан гэжээ. Мөн ИДС төгсөгчдийн 3.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 4.7 хувь нь мэргэжил сонголтдоо сэтгэл ханамжгүй байна.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 6. Суралцах хугацаандаа илүү эзэмших шаардлагатай байсан гэж үзсэн мэдлэг, чадвар, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь



### 2.3. ТӨГСӨГЧДИЙН ДАХИН СУРАЛЦАЖ БҮЙ СУРГАЛТ

Тайлангийн энэ хэсэгт дахин суралцагчдын сургалтын төрөл, шалтгаан, одоогийн сурч буй мэргэжлийн чиглэл болон өмнө эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал, адил мэргэжлээр суралцаагүй шалтгаан зэргийг авч үзнэ. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд төгсөгчдийн 9.6 хувь нь мэргэжлийн түр сургалт болон мэргэжлийн анхан шат ба түүнээс дээш боловсрол олгох сургалтад хамрагдаж байв.

Сүүлийн нэг жилийн хугацаанд нийт МБСБ төгсөгчдийн 7.9 хувь нь, ИДС төгсөгчдийн 10.6 хувь нь боловсролын түвшин ба зэрэг ахиулах, мэргэжил, ур чадвар эзэмшихээр дахин суралцсан. Дахин суралцаж буй ИДС төгсөгчдийн 48.2 хувь нь магистрын зэргийн, 32.4 хувь нь мэргэжлийн түр сургалтын байгууллагад, 16.9 хувь нь бакалаврын зэргийн, МБСБ төгсөгчдийн 69.2 хувь нь бакалаврын зэргийн, 16.5 хувь нь мэргэжлийн түр сургалтын байгууллагад суралцаж байна.

Зураг 7. Дахин суралцагчдын сургалтын төрөл

Хэмжих нэгж: хувь




Дахин суралцаж буй төгсөгчдийн 29.4 хувь нь өмнө нь суралцаж төгссөн сургуулиа сонгосон бол 70.6 хувь нь өөр сургуульд сурч байгааг сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгсөгчдийн 60.5 хувь, МБСБ төгсөгчдийн 88.2 хувь нь өмнө суралцаж төгссөн сургуулиасаа өөр сургууль сонгон суралцаж байна.

Мэргэжлийн түр сургалтаас бусад сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдын 44.4 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 33.0 хувь нь боловсролын түвшин, зэрэг ахиулах, 8.5 хувь нь сонирхсон ажилдаа орохын тулд, 8.1 хувь нь давхар мэргэжил эзэмших, 4.5 хувь нь ажлын шаардлагаар дахин суралцжээ.

#### Зураг 8. Дахин суралцаж буй шалтгаан


Хэмжих нэгж: хувь




ИДС төгсөгчдийн 22.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 62.1 хувь нь огт өөр мэргэжлээр дахин суралцаж байгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Үргэлжлүүлэн ижил мэргэжлээр суралцаж буй ИДС төгсөгчдийн хувьд анагаах ухааны чиглэлээр төгсөгчид дийлэнх нь байна.

#### Зураг 9. Эзэмшсэн болон одоо суралцаж буй мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь



Төгсөгчид боловсролын түвшин зэрэг ахиулах, эзэмшсэн мэргэжил хувийн сонирхол, зан төлөвт тохирдоггүй, давхар мэргэжил эзэмших, ажлын шаардлагаар, мэргэжлээ солихын тулд гэсэн шалтгаануудаар дахин суралцаж байна. Огт өөр эсхүл төсөөтэй мэргэжлээр дахин суралцаж буй МБСБ төгсөгчдийн 29.5 хувь нь боловсролын түвшин зэрэг ахиулах, 27.7 хувь нь эзэмшсэн мэргэжил хувийн сонирхол, зан төлөвт тохирдоггүй, 11.4 хувь нь ажлын шаардлагаар, 7.9 хувь хувь нь өсөн дэвших, хөгжих боломж багатайн улмаас, ИДС төгсөгчдийн 29.9 хувь нь давхар мэргэжил эзэмших, 22.5 хувь нь боловсролын түвшний зэрэг ахиулах, 17.5 хувь нь эзэмшсэн мэргэжил хувийн сонирхол, зан төлөвт тохирдоггүй, 11.9 хувь нь мэргэжлээ солихын тулд, 10.4 хувь нь ажлын шаардлагаар дахин суралцаж байна.



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

III

БҮЛЭГ  
ТӨГСӨГЧДИЙН  
2020 ОНЫ ЭДИЙН  
ЗАСГИЙН ИДЭВХ

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Энэ бүлэгт төгсөгчдийн 2020 оны эдийн засгийн идэвхийг авч үзнэ. Судалгааны дүнгээр төгсөгчдийн 79.3 хувь нь ажиллах хүч, 20.7 хувь нь ажиллах хүчинээс гадуурх /хуучнаар эдийн засгийн идэвхгүй/ төгсөгчид байна. Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй байгаа төгсөгчдийн 59.4 хувь нь Улаанбаатарт, 40.6 хувь нь орон нутагт оршин сууж байна.

Нийт төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж, 4.5 хувь нь ажилгүй, 20.7 ажиллах хүчинээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй байгаа юм. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 76.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 71.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Зураг 10. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр



Төгсөгчдийн хөдөлмөрийн дутуу ашиглалтийн буюу ажилгүй төгсөгчид болон боломжит ажиллах хүчиний нэгдсэн түвшинг тооцож үзэхэд нийт төгсөгчдийн 13.7 хувьд нь хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байна. Энэ нь ИДС төгсөгчдийн 14.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 13.6 хувь нь байна.

Нийт боломжит ажиллах хүчиний 4.1 хувь нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байгаа, ур чадварт тохиорох ажил байхгүй, туршлага байхгүй, ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу гэж үздэгийн улмаас итгэл алдарсан байна. Тэдгээрийн 71.2 хувь нь эрэгтэй, 28.8 хувь нь эмэгтэйчүүд, мөн 41.9 хувь нь ИДС төгсөгч, 58.1 хувь нь МБСБ төгсөгч байна.

### 3.1. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ

Тус судалгааны нэг зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахад чиглэгдсэн. Тайландийн энэ бүлэгт төгсөгчдийн тухайн үеийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах юм.

Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 48.8 хувь нь эрэгтэйчүүд, 51.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 76.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 71.5 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 89.7 хувь нь байнгын, 7.7 хувь нь улирлын чанартай, 2.6 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна. МБСБ төгсөгчдийн 18.2 хувь нь, ИДС төгсөгчдийн 5.7 хувь нь түр болон улирлын чанартай ажлын байранд ажиллаж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 82.3 хувь нь цалин хөлстэй ажилтан, 12.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.4 хувь нь ажил олгогч, 3.0 хувь нь мал аж ахуй эрхлэгч байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ЭЗҮА-ны салбараар авч үзвэл 11.9 хувь нь боловсролын, 11.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.6 хувь нь үйлчилгээний, 9.2 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгссөн ажиллагчдын 15.1 хувь нь боловсролын, 10.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 9.8 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 9.6 хувь нь үйлчилгээний салбарт, МБСБ төгссөн ажиллагчдын 14.6 хувь нь барилгын, 13.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 12.4 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 9.8 хувь нь уул уурхай, олборлолт, 8.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

#### Хүснэгт 6. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	ИДС төгссөгч	МБСБ төгссөгч	Бүгд
Боловсрол	15.1	6.4	11.9
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклийн засвар үйлчилгээ	10.3	13.1	11.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9.6	12.4	10.6
Барилга	6.0	14.6	9.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	9.8	5.8	8.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн хalamжийн үйл ажиллагаа	8.7	5.4	7.5
Уул уурхай, олборлолт	5.7	9.8	7.2
Боловсруулах үйлдвэрлэл	6.3	8.3	7.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9.4	0.3	6.1
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3.3	6.9	4.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3.5	6.0	4.4
Мэдээлэл, холбоо	4.4	0.6	3.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.3	3.4	2.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.2	1.8	1.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.9	0.7	1.4
Ус хангамж: Бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.8	2.1	1.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.5	0.8	1.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.6	1.1	0.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.5	0.3	0.4
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр нь харахад барилга архитектурын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 89.6 хувь нь, тээврийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 89.2 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь хамгийн өндөр хөдөлмөр эрхлэлттэй байна. Хамгийн бага хөдөлмөр эрхэлж буй нь багш, боловсрол судлал, хүмүүнлэгийн ухаан мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийг байна.

#### Зураг 11. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр


Хэмжих нэгж: хувь



МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мэргэжлийн чиглэлээр харахад тээврийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 84.1 хувь, эрчим хүчний мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 83.4 хувь нь, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 81.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь бусад мэргэжлийн чиглэлээр төгсөгчидтэй харьцуулахад өндөр байна. Харин боловсрол болон үйлчилгээний мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн бага байна.

Зураг 12. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



Төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг тандах зорилгоор ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдлын талаар асууж, огт тохирдоггүйгээс маш тохиромжтой хүртэл 1-4 баллаар үнэлүүлсэн. Төгсөгчдийн 15.0 хувь нь маш тохиромжтой, 45.9 хувь нь тохиромжтой гэж үзсэн бол 39.1 хувь нь тохирдоггүй буюу мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байна. МБСБ төгсөгчдийн

49.0 хувь нь, ИДС төгсөгчдийн 33.5 хувь нь эзэмшсэн мэргэжилтэйгээ тохирохгүй ажил хийдэг байна.

**Хүснэгт 7. Эрхэлж буй ажил болон эзэмшсэн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр**

Хэмжих нэгж: хувь

Сургуулийн төрөл	Огт тохиromжгүй	Тохиromжгүй	Тохиromжтой	Маш тохиromжтой	Бүгд
ИДС төгсөгч	6.7	26.8	49.0	17.5	100.0
МБСБ төгсөгч	12.5	36.6	40.4	10.6	100.0
<b>Бүгд</b>	<b>8.8</b>	<b>30.3</b>	<b>45.9</b>	<b>15.0</b>	<b>100.0</b>

Тодорхой цаг хугацаа, хөрөнгө зарцуулан эзэмшсэн мэргэжилтэйгээ тохирохгүй, мэргэжлийн бус ажил хийх явдал МБСБ төгссөн 10 төгсөгч тутмын 4-д нь, ИДС төгссөн 10 төгсөгч тутмын 3-д тохиолдож байгааг анхаарахгүй орхиж болохгүй юм.

Төгсөгчид хөдөлмөр эрхэлж байгаа нь чухал хэдий ч тэд сургуульд суралцаж эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг тандан, судлах хэрэгтэй. Төгссөнөөс хойш 4 жилийн дараах байдлаар ИДС төгсөгчдийн 76.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 66.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байгаа юм.

ИДС төгсөгчдийн хувьд эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байгаа хувь өндөр мэргэжлийн чиглэлүүдэд анагаах ухаан (86.5 хувь), мал эмнэлэг (84.9 хувь), багш, боловсрол судлал (80.8 хувь) зэрэг байна.

Харин ХАА, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт хамгийн бага байна.

### Зураг 13. ИДС төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт

Хэмжих нэгж: хувь



МБСБ төгсөгчдийн 71.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 51.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Эрүүл мэнд (83.0 хувь), эрчим хүч

(74.7 хувь), үйлчилгээний салбарт (67.5 хувь) хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах нь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад өндөр байна. Харин боловсрол, мэдээллийн технологи, байгаль орчин, аялал жуулчлал, ХАА-н мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй 10 төгсөгч тутмын б нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байна.

МБСБ төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 5 нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгааг бодлого боловсруулагчид, сургалтын байгууллагууд анхааралдаа авах хэрэгтэй. Хөдөлмөрийн зах зээлийн шингээлт бага мэргэжлээр элсэлт авах, эсвэл тухайн ажлын байранд ур чадварын зөрүү гарах, мэргэжил сонголтын алдаа байгаа эсэхэд анхаарал хандуулж цаашид нарийвчилсан судалгаа хийх зайлшгүй шаардлагатай юм.

Зураг 14. МБСБ төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлт

Хэмжих нэгж: хувь




Хөдөлмөр эрхэлж байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодрууллаа. Зонхилох шалтгаанд тухайн эзэмшсэн мэргэжлийн ажлын байр хомс, одохгүй байгаа, цалин бага, мэргэжлээрээ ажиллах сонирхол байхгүй, ажилласан жилийн туршлага шаарддаг, одоо ажиллаж буй ажилдаа сэтгэл ханамжтай, өөрийнхөө сонирхлоороо ажиллах байгаа, хувийн болон гэр бүлийн бизнес эрхэлж байгаа зэрэг орж байна.

Мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй, мэргэжилдээ сэтгэл ханамжгүй, өөр мэргэжлээр ажиллаж байгаа ч тухайн ажилдаа сэтгэл ханамжтай байгаа зэргээс харахад нийт төгсөгчдийн 10 гаруй хувьд мэргэжил сонголтын алдаа байна.

Зураг 15. Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллахгүй зонхилох шалтгаан, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 45.4 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компанийд, 25.2 хувь нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад, 12.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. ИДС төгсөгчдийн 44.2 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компанийд, 30.4 хувь нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад, 10.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол МБСБ төгсөгчдийн 47.3 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компанийд, 16.3 хувь нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад, 15.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 28.7 хувь нь цалин хөлстэй ажилтнаас илүү орлого олох, 14.1 хувь нь бизнес, аж ахуй эрхлэх нь хувийн зан чанарт тохирно, 8.7 хувь нь ААНБ-д цагт баригдаж ажиллах сонирхолгүй, 8.1 хувь нь амжилт гаргах, хөгжих боломжтой учраас хувиараа бизнес эрхэлдэг гэсэн байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр 5, ажлын дундаж цаг 49, нэмэлт ажлын цаг 3 гэсэн үр дүн гарчээ. Төгсөгчдийн сарын дундаж ажлын өдөр 23, амралтын өдөр 7 байна. Долоо хоногт МБСБ төгсөгчид, ИДС төгсөгчдөөс 8 цагаар илүү ажиллаж байна.

Ажиллагчдын авдаг цалин, бизнесээс олж буй орлогыг тодруулахад төгсөгчдийн сарын дундаж цалин, орлого нь 935.6 мянган төгрөг байна. Сургуулийн төрлөөр нь харьцуулбал ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин, орлого нь 977.2 мянган төгрөг бол МБСБ төгсөгчдийнх 864.4 мянган төгрөг байна.

**Хүснэгт 8. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажлын дундаж хугацаа, сарын дундаж цалин орлого, сургуулийн төрлөөр**


Ангилал	7 хоногийн дундаж			Сарын дундаж		
	Ажлын өдөр	Ажлын цаг	Илүү ажлын цаг	Ажлын өдөр	Амралтын өдөр	Цалин
ИДС тögсөгч	5	46	4	22	7	977 265
МБСБ тögсөгч	6	54	3	23	7	864 411
Дундаж	5	49	3	23	7	935 680

ИДС төгсөгчдөөс барилга, архитектур, бүх төрлийн инженер, компьютер, үйлдвэрлэлийн технологи, тээвэр, хими, физик, геологи, газар зүй, нийгэм, эдийн засаг мэргэжлээр ажиллагчид 1 сая ба түүнээс дээш төгрөгийн цалин авч буй нь бусад мэргэжлийн чиглэлээр төгсөгчидтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт.

Хамгийн бага цалинтай ажиллагчдад мал эмнэлэг, нийгмийн халамж, хангамж, багш, боловсрол судлал мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байна.

**Зураг 16. Хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр**

Хэмжих нэгж: мян.төг



МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогыг мэргэжлийн чиглэлээр харвалуулурхай 1033.1 мянга, тээвэр 937.1 мянга, барилга 919.3 мянган төгрөгийн цалин авдаг нь бусад мэргэжлийн чиглэлээр төгсөгчидтэй харьцуулахад өндөр байна. Харин эрүүл мэнд, эрчим хүч, боловсрол, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид бусад мэргэжлээр төгсөгчидтэй харьцуулахад бага цалин авч байна.

Зураг 17. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: мян.төг



ЭЗҮА-ны салбараар сарын дундаж цалин, орлогын хэмжээг тодруулахад хамгийн өндөр цалин авч ажиллаж буй салбар нь уул уурхай, олборлолт 1520.2 мянга, ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа 1350.0 мянга, тээвэр, агуулахын үйл ажиллагаа 1231.9 мянга, барилга 1171.7 мянга, цахилгаан, хий, уур, агааржуулалт 1034.6 мянган төгрөг байна. ХАА, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа салбарт ажиллаж буй төгсөгчдийн цалин, орлого хамгийн бага байна.

Хүснэгт 9. Төгсөгчдийн сарын дундаж цалин, орлого, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: мян.төг

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Уул уурхай, олборлолт	1640.6	1398.7	1520.2
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1350.0	-	1350.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1322.8	1141.2	1231.9
Барилга	1339.8	1052.0	1171.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1168.0	883.4	1034.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1252.3	300.0	995.4
Мэдээлэл, холбоо	1007.0	751.9	987.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1056.4	812.9	951.8
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	1075.8	784.0	951.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	956.3	922.4	948.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	971.4	784.5	938.9
Боловсруулах үйлдвэрлэл	1053.6	787.1	938.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	927.4	644.3	921.7
Үс хангамж: Бохир ус зайлзуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1062.1	819.8	915.2

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	914.1	743.0	810.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	820.8	705.1	790.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	700.1	731.8	708.1
Боловсрол	711.2	667.1	702.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	557.4	500.8	529.4
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	665.1	414.1	526.9
<b>Бүгд</b>	<b>977.5</b>	<b>865.4</b>	<b>936.4</b>

Төгсөгчид ажил олгогчтой гэрээ байгуулж ажиллах нь ажлын байр баталгаатай байх үндэс болдог. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 85.6 хувь нь ямар нэг гэрээ байгуулан ажиллаж байна. Харин ИДС төгсөгчдийн 90.3 хувь нь МБСБ төгсөгчдийн 76.7 хувь нь ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан байна. МБСБ төгсөгчдийн 23.3 хувь нь гэрээгүй ажиллаж байгаа нь өмнөх оноос 7.6 пунктээр буурчээ.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид 100.0 хувь нь гэрээ байгуулан ажиллаж байхад ХАА-н салбар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд гэрээ байгуулан ажиллах хувь бага байна. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахгүй байх нь төгсөгчдийн ажлын байр нь баталгаагүй, татвар даатгалд хамрагдахгүй байх сул талтай байдаг.

**Хүснэгт 10. Гэрээтэй хөдөлмөр эрхэлж буй эсэх, ЭЗҮА-ны салбараар**

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Гэрээтэй	Гэрээгүй	Бүгд
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	100.0	0.0	100.0
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	100.0	0.0	100.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	98.9	1.1	100.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	94.8	5.2	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	93.7	6.3	100.0
Мэдээлэл, холбоо	93.3	6.7	100.0
Боловсрол	93.1	6.9	100.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	91.2	8.8	100.0
Уул уурхай, олборлолт	90.4	9.6	100.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	88.4	11.6	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	86.0	14.0	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	84.2	15.8	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	83.6	16.4	100.0
Үс хангамж: Бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цвэрэлэх үйл ажиллагаа	83.6	16.4	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	76.4	23.6	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	76.2	23.8	100.0
Барилга	75.9	24.1	100.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	74.0	26.0	100.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	65.7	34.3	100.0
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	64.5	35.5	100.0
<b>Бүгд</b>	<b>85.7</b>	<b>14.3</b>	<b>100.0</b>

Гэрээ байгуулан ажиллаж буй төгсөгчдийн 96.4 хувь нь хөдөлмөрийн гэрээ, 3.6 хувь нь ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй төгсөгчдийн 37.4 хувь нь хугацаатай, 62.6 хувь нь хугацаагүй гэрээ байгуулсан байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 74.8 хувь нь албан журмаар, 4.8 хувь нь сайн дураар нийгмийн даатгалд даатгуулсан бол үлдсэн 20.5 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байна. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн 39.5 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байгаа нь анхаарал татаж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 87.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол 76.7 хувь нь хүн амын орлогын албан татвар төлж байна.

**Хүснэгт 11. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн даатгал, татварын үзүүлэлт**


Хэмжих нэгж: хувь

Сургуулийн төрөл	Нийгмийн даатгал			Эрүүл мэндийн даатгал	
	Албан журмаар даатгуулагч	Сайн дураар даатгуулагч	Төлдөггүй	Төлдөг	Төлдөггүй
ИДС төгсөгч	83.6	4.5	11.9	92.2	7.8
МБСБ төгсөгч	59.6	5.2	35.2	79.0	21.0
<b>Бүгд</b>	<b>74.8</b>	<b>4.8</b>	<b>20.5</b>	<b>87.4</b>	<b>12.6</b>

Эзэмшсэн боловсролын түвшин ажлын байранд нь шаардлагатай боловсролын түвшинтэйний цэж байгаа эсэхийг судлахад 76.1 хувь нь тохиромжтой, 12.5 хувь нь эзэмшсэн боловсролын түвшингээс доогуур, 11.4 хувь нь эзэмшсэн боловсролын түвшнээс илүү шаардлага бүхий ажлын байранд ажиллаж байна. Хөдөлмөр эрхэлж буй нийт төгсөгчдийн 23.9 хувьд нь боловсролын үл нийцлээс хамаарсан бэрхшээл байдаг гэжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 4.7 пунктээр буурсан дүн юм.

**Зураг 18. Эзэмшсэн боловсрол, АБ-нд шаардагдах боловсролын түвшний нийцэл**  
Хэмжих нэгж: хувь

■Хэт доогуур ■Доогуур ■Тохиромжтой ■Өндөр ■Хэт өндөр



Эзэмшсэн боловсрол, ажлын байрны нийцэл, ажлын байранд ороход нөлөөлсөн хүчин зүйлсээс гадна ажлын байранд шаардагдах ур чадварын шаардлага, суралцах хугацаандаа эзэмшсэн ур чадвар хоорондын нийцлийг 5 түвшнээр хэмжсэн.

Төгсөгчдийн ажлын байрны ур чадварын шаардлага, эзэмшсэн ур чадвартай харьцуулахад 78.9 хувь нь тохиромжтой, 10.4 хувь өндөр, хэт өндөр гэсэн бол 10.7 хувь нь доогуур, хэт доогуур гэжээ. Мөн ур чадварын дутагдлаас үүдэлтэй

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

хөдөлмөр эрхлэлтийн хүндрэл, бэрхшээл төгсөгчдийн 10 гаруй хувьд нь байсаар байна.

Зураг 19. АБ-нд шаардагдах ур чадвар, эзэмшсэн ур чадварын нийцэл

Хэмжих нэгж: хувь




Зарим төгсөгчид өөрийн эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшинг ажлын байрны шаардлагаас доогуур гэж үнэлсэн нь ажилтан, ажил олгогчийн шаардлагад тэнцэхгүй объектив, хувь хүний хүчин зүйлстэй холбоотой субъектив шалтгаантай байж болох ч боловсролын байгууллагуудын сургалтын чанарыг харуулах хэмжүүр байж болох талтай.

Одоогийн эзэмшсэн ур чадвараа хэзээ олж авсныг тодруулахад төгсөгчдийн 70.8 хувь нь ажиллаж эхэлсний дараа, 29.2 хувь нь суралцаж байх хугацаандаа ур чадвараа эзэмшсэн гэжээ. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 73.3 хувь нь, МБСБ төгсөгчдийн 66.5 хувь нь ажилд орсны дараа ур чадвараа эзэмшсэн байна.

Зураг 20. Ур чадвараа эзэмшсэн байдал, сургуулийн төрлөөр


Хэмжих нэгж: хувь



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 22.7 хувь нь ажлын туршлага дутах, 17.0 хувь нь ажлын ачаалал, орчин нөхцөл, 15.4 хувь нь ажлын хэв маягт дасах, 13.0 хувь нь хамт ажиллагсад, удирдлагатай харилцах харилцаа зэрэг хүчин зүйлс тухайн ажлын байранд дасан зохицоход гол бэрхшээл болж байжээ.

Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөд суралцах хугацаандаа олж авсан мэдлэг тухайн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэхэд тус болж чадаж байгаа эсэхийг тодруулахад 83.5 хувь нь тус болдог, 16.5 хувь нь тус болдоггүй гэжээ. Мөн суралцаж байх хугацаандаа эзэмшсэн ур чадвар нь ажил үүргээ гүйцэтгэхэд хэр тус болж байгааг тодрууллаа.

Зураг 21. Суралцах хугацаандаа олж авсан ур чадварын хэрэглээ, ашиглалт  
Хэмжих нэгж: хувь



Суралцах хугацаандаа эзэмшсэн мэргэжлийн ур чадвар тухайн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэхэд 75.5 хувьд нь тус болдог бол 15.0 хувьд нь тус болдоггүй. Сургуулийн төрлөөр нь харвал МБСБ төгсөгчдийн 22.4 хувь нь, ИДС төгсөгчдийн 13.7 хувьд нь эзэмшсэн мэргэжлийн ур чадвар нь тухайн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэхэд тус болоогүй гэжээ.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 83.3 хувь нь тухайн ажлын байрандаа тогтвортой ажиллах төлөвлөгөөтэй бол 16.7 хувь нь тийм төлөвлөгөөгүй байна. Тогтвортой ажиллах төлөвлөгөө бүхий ажиллагчдын 31.8 хувь нь ажилдаа сэтгэл ханамжтай, 20.7 хувь нь өсөн хөгжих боломжтой, 16.8 хувь нь цалин хангамж сайн, 16.3 хувь нь ажил, амралтын цаг тохиромжтой зэрэг шалтгааныг дурдажээ.

Цаашид тогтвортой ажиллах төлөвлөгөөгүй ИДС төгсөгчдийн 16.9 хувь нь ажлын нөхцөл, цалин хангамж муу, 16.6 хувь нь түр ажиллаж байгаа, 15.2 хувь нь мэргэжлээрээ ажиллах сонирхолтой, 14.0 хувь нь илүү өсөн хөгжих боломжтой ажил хийх зэрэг шалтгааныг дурдсан бол МБСБ төгсөгчдийн 23.4 хувь нь түр ажлын байр, 16.2 хувь нь ажлын нөхцөл, хангамж муу, 9.6 хувь нь илүү хөгжих боломжтой, нөхцөл сайтай ажил хийх, 9.6 хувь нь суралцах хүсэлтэй, 9.4 хувь нь мэргэжлээрээ ажиллагаар байгаагаа илэрхийлжээ.

Төгсөгчдийн ажлын байрны сэтгэл ханамжийг 10 үзүүлэлтээр 4 баллаар үнэлүүлсэн. Төгсөгчдийн сэтгэл хамгийн ханамжтай байдаг ажлын байрны үзүүлэлт бол байгууллагын нэр хүнд, хариуцаж буй ажил үүрэг, ажлын орчин, ХАБЭА гэж үнэлжээ. Харин цалиндаа сэтгэл хангалааныг дурдажээ.

#### Хүснэгт 12. Ажлын байрны сэтгэл ханамжийн үнэлгээ, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: дундаж

Хүчин зүйл	ИДС төгсогч	МБСБ төгсогч	Бүгд
Байгууллагын нэр хүнд	3.2	3.1	3.2
Хариуцаж буй ажил үүрэг	3.1	3.1	3.1
Ажлын орчин	3.0	3.0	3.0
Хөдөлмерийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	3.0	3.0	3.0
Ажил мэргэжлийн үнэлэмж	2.9	3.0	3.0
Ажлын байрны хангамж	2.9	3.0	3.0
Ажил, амралтын цаг	2.9	2.9	2.9
Өсөн хөгжих боломж	2.9	2.9	2.9
Хүний нөөцийн менежмент	2.9	2.9	2.9
Цалин	2.8	2.9	2.8

Сургууль төгссөнөөс хойш 4 жилийн дараах байдлаар хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хамгийн ихээр нэрлэсэн тухайн ажлын байранд тулгардаг ерөнхий ур чадварын дутагдал нь багаар ажиллах, харилцааны, бие даан ажиллах, шийдвэр гаргах зэрэг чадварууд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзэхэд ИДС төгсөгчдийн хувьд багаар ажиллах, харилцааны, цаг ашиглах, шийдвэр гаргах чадвар, МБСБ

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

төгсөгчдийн хувьд багаар ажиллах, харилцааны, бие даан ажиллах чадварууд илүү дутагдаж байгаагаа илэрхийлжээ. Тухайн ур чадваруудыг ИДС болон МБСБ-д сургахаас илүүтэй бага, дунд боловсрол олгох байгууллагаас нь эзэмшүүлж эхлэх хэрэгтэй байх.

Хүснэгт 13. Ажлын байран дахь ерөнхий ур чадварын хомсдол, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь

Үр чадвар	ИДС төгсогч	МБСБ төгсогч	Бүгд
Багаар ажиллах чадвар	19.3	24.7	21.1
Харилцааны ур чадвар	14.9	15.5	15.1
Бие даан ажиллах	7.1	11.3	8.5
Шийдвэр гаргах чадвар	8.4	9.8	8.8
Цаг ашиглах чадвар	8.5	8.7	8.6
Ярианы чадвар	7.5	6.0	7.0
Тасралтгүй суралцах чадвар	7.7	5.9	7.1
Зохион байгуулах	7.1	5.8	6.6
Асуудал шийдвэрлэх чадвар	8.4	4.0	6.9
Шүүн тунгаах чадвар	4.0	2.9	3.6
Бичих чадвар	3.9	2.8	3.6
Өөрчлөлтөд дасан зохицох чадвар	3.2	2.5	3.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Ажиллаж буй ажлын байранд дутагдаж буй мэргэжлийн ур чадваруудыг тодруулахад нийт төгсөгчдөд гадаад хэл, компьютерын мэдлэг, баримт бичиг боловсруулах, мэргэжлийн мэдлэг, чадвар дутагджээ. Хөдөлмөр эрхэлж байх хугацаанд ИДС төгсөгчдийн хувьд гадаад хэл, компьютерын мэдлэг, баримт бичиг боловсруулах, мэргэжлийн мэдлэг, МБСБ төгсөгчдийн хувьд гадаад хэл, компьютер, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, компьютерын мэдлэг, мэргэжлийн мэдлэг дутагдсан гэсэн байна. МБСБ төгсөгчдийн мэргэжлийн онцлогоос болж байна уу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг илүү дутагдсан байна үүнд анхаарал хандуулах хэрэгтэй юм.

Судалгааны 4 жилийн хугацаанд хамгийн ихээр дутагдаж буй ур чадвар нь англи хэлний мэдлэг байв. Англи хэлний ерөнхий мэдлэгийг 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөрт илүү тусгаж, харин их, дээд, мэргэжлийн боловсрол олгох сургалтад мэргэжлийн англи хэлний мэдлэгийг эзэмшүүлэх шаардлагатай юм. Аливаа бүтээгдэхүүний заавар, найрлага, эмийн заавар унших зэрэгт гадаад хэлний мэдлэг илт дутагдаж буйгаа төгсөгчид хэлж байсан. Мөн зарлагдаж буй шинэ, сүл ажлын байранд хэлний мэдлэгтэй байх нь ажил горилогчийн нэг давуу тал болж байдаг.

Зураг 22. Ажлын байран дахь мэргэжлийн мэдлэг, ур чадварын хомсдол, сургуулийн төрөлд эзлэх хувь



Төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд ажлын байр олоход ажлын туршлага дутах, ажлын байрны хомсдол, ажлын байрны мэдээллийн хомсдол, мэргэжлийн ур чадварын дутмаг байдал зэрэг бэрхшээл голлон тулгарч байсан гэж хариулсан. Одоогийн ажиллаж буй ажлын байранд мэдээллийн ямар эх сурвалж ашиглан орсныг тодруулахад 24.8 хувь нь эцэг, эх хамаатан садан, 22.8 хувь нь интернет, 20.7 хувь нь найз, хамт суралцагсад, 8.8 хувь нь ажил олгогчоос мэдээлэл авчээ.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 4.9 хувь нь давхар хөдөлмөр эрхэлж байна. Хийж буй давхар ажил нь үндсэн ажлын чиг үүрэгтэй харьцуулахад адил салбарт хамаарч байгаа эсэхийг тодруулахад 26.8 хувь нь адил, 17.7 хувь нь төстэй, 55.6 хувь нь огт өөр салбар байна. Төгсөгчдийн 68.7 хувь нь санхүүгийн боломжоо нэмэгдүүлэх, 9.3 хувь нь ур чадвараа дээшлүүлэх зорилгоор давхар хөдөлмөр эрхэлсэн байна.

### 3.2. ТӨГСӨГЧДИЙН АЖИЛГҮЙДЭЛ, АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ

Нийт төгсөгчдийн 4.5 хувь нь ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаагаас 25.8 хувь нь эрэгтэйчүүд, 74.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл нь МБСБ төгсөгчдийн 5.2 хувь нь, ИДС төгсөгчдийн 4.0 хувь нь ажилгүй байна. Ажилгүй төгсөгчдийн 50.2 хувь нь нийслэлд, 49.2 хувь нь орон нутагт оршин сууж байна.

Ажилгүй байгаа ИДС-ийн нийгмийн халамж, хангамж мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 6.7 хувь нь, үйлдвэрлэлийн технологи мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 5.2 хувь нь, бизнесийн удирдлага мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 4.9 хувь нь ажил эрхлээгүй. Судалгааны 4 дэх жилийн үр дүнгээр төгссөнөөс хойш жил нэмэгдэх тусам ажилгүй байх төгсөгчдийн тоо буурч байгаа юм.

Зураг 23. Ажилгүй байгаа ИДС төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр


Хэмжих нэгж: хувь



МБСБ-ыг үйлчилгээний мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 11.0 хувь, хөдөө, аж ахуйн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 6.9 хувь, боловсролын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 6.9 хувь нь, байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 6.6 хувь нь ажилгүй байна.

Зураг 24. Ажилгүй байгаа МБСБ төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь




Ажилгүй байгаа эмэгтэй төгсөгчдийн 55.0 хувь нь хүүхэд асрах, жирэмсэн, 11.3 хувь нь ажил хайгаад олдохгүй, 10.1 суралцдаг, 4.2 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй зэргийн улмаас ажилгүй байгаа бол, эрэгтэй төгсөгчдийн 22.5 хувь нь ажил хайгаад олдохгүй, 22.0 хувь нь суралцдаг, 13.3 хувь нь хувийн шалтгаан, 8.1 хувь нь ажиллах сонирхолгүй зэрэг шалтгаан тоочсон байна.

Харин ИДС төгсөгчдийн 49.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 36.9 хувь нь хүүхэд асрах, харах, жирэмсэн шалтгаантай байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна. Мөн ИДС төгсөгчдийн 13.6 хувь нь суралцдаг, 9.9 хувь нь ажил хайгаад олдохгүй, 7.3 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй зэрэг шалтгаан түлхүү байна. Харин МБСБ төгсөгчдийн 36.9 хувь нь хүүхэд харах, асрах, 18.9 хувь нь ажил хайгаад олдохгүй, 12.2 хувь нь суралцдаг, 7.8 хувь нь хувийн шалтгааны улмаас ажил хийхгүй байна гэжээ.

## БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧДИЙН 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

**Зураг 25. Төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгаан, сургалтын төрлөөр**

Хэмжих нэгж: хувь



### АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ

Нийт төгсөгчдийн 9.6 хувь нь ажил хайж байгаа бөгөөд тэдний 39.3 хувь нь ажил хийх, 11.7 хувь нь одоогоор ажил хийж байгаа ч ажлаа солих, 49.0 хувь нь давхар хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байна. Ажлаа солих зорилготой төгсөгчдийн 15.9 хувь нь одоо ажиллаж байгаа ажлаа ирээдүйгүй, 12.0 хувь нь мэргэжлээрээ ажилд орох, 11.0 хувь нь ажилдаа ирж, явахад урт хугацаа зарцуулдаг, 10.0 хувь нь цалин хөлс бага, 7.7 хувь нь өсөн хөгжих боломжгүй гэсэн шалтгаануудыг голчлон нэрлэсэн байна.

Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг хүчин зүйлийг 11 үзүүлэлтээр авч үзсэн бөгөөд 4 хүртэлх баллаар үнэлүүлсэн. Ажил хайж буй төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, ажил мэргэжлийн ирээдүй, өсөн хөгжих боломж, цалин, ажлын орчин, цаг зэргийг илүү чухалчилж үзжээ.

**Хүснэгт 14. Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг хүчин зүйл, сургуулийн төрлөөр**

Хүчин зүйл	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	3.0	3.1	3.1
Ажил, мэргэжлийн ирээдүй	3.0	3.1	3.1
Өсөн хөгжих боломж	3.1	3.0	3.0
Цалин	3.0	3.0	3.0
Ажлын орчин	2.9	3.0	3.0
Ажлын цаг	3.0	2.9	3.0
Ажлын ачаалал	2.7	2.8	2.8
Хувийн зан чанарт нийцэх байдал	2.9	2.8	2.9
Ажлын чиг үүргийн хүндрэл	2.7	2.7	2.7
Ажил, гэр хоорондын зай	2.5	2.6	2.5
Байгууллагын нэр хүнд	2.6	2.6	2.6

Ажил хайж буй төгсөгчдийн ажилдороход тулгардаг бэрхшээлийг тодруулахад 26.3 хувь нь ажлын байрны мэдээллийн хомсдол, 18.7 хувь нь ажлын туршлага дутах, 10.7 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 7.5 хувь нь ажлын орчин, цаг зэрэг хүчин зүйлийг түлхүү дурдجээ.

### 3.3. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ТӨГСӨГЧИД /ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ БАЙДАЛ/

Нийт төгсөгчдийн 20.7 хувь нь ажиллах хүчинээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй төлөвт байна. ИДС төгсөгчдийн 19.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 23.3 хувь нь ажиллах хүчинээс гадуур байгаа бөгөөд байршлын хувьд 57.3 хувь нь Улаанбаатарт, 42.7 хувь нь хөдөө, орон нутагт оршин сууж байна. Ажиллах хүчинээс гадуурх төгсөгчдийн 21.1 хувь нь эрэгтэй, 78.9 хувь нь эмэгтэй байна.

Сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил олох болон бизнес эрхлэх гэж оролдоогүй ажиллах хүчинээс гадуур байгаа төгсөгчдийн 74.1 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 7.4 хувь нь суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа зэрэг шалтгаантай байгаа юм.

#### БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ

Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дуттуу ашиглалт” олон улсын статистикийн стандарт арга зүйн бичгийг баталж, улс орнуудыг дагаж мөрдөхийг зөвлөмж болгосон. Үүнийг дагуу 2019 оны 1 дүгээр сард YCX-ны дарга, XHX-ын сайдын хамтарсан тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг олон улсын арга зүйд нийцүүлэн шинэчлэн баталсан. Ингэснээр хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаар илүү нарийвчилсан үзүүлэлтүүдийг тооцон гаргах боломжтой болсон.

XHXSИ нь тухайн аргачлалд нийцүүлэн уг судалгааны хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг тооцоходоо өөрчлөлт оруулан шинээр мөрдөгдөж эхэлсэн боломжит ажиллах хүч, итгэл алдarsан ажил хайгч, ажил хийгээгүй болон суралцаагүй залуучууд гэсэн үзүүлэлтийг тооцсон болно.

Ажиллах хүчинээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй байгаа төгсөгчдийн 40.4 хувь нь цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боломжит ажиллах хүч байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл ажиллах хүчинээс гадуур байгаа ИДС төгсөгчдийн 33.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 49.3 хувь нь боломжит ажиллах хүч байна. Боломжит ажиллах хүчиний 30.2 хувь нь эрэгтэй, 69.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Боломжит ажиллах хүчийг оршин суугаа бүсээр харвал 50.9 хувь нь Улаанбаатарт, 17.1 хувь нь Хангайн, 13.2 хувь нь Баруун, 14.8 хувь нь Төвийн, 4.1 хувь нь Зүүн бүсэд байна. Харин сургуулийн төрлөөр ИДС төгсөгчдийн 69.8 хувь нь Улаанбаатарт, МБСБ төгсөгчдийн 66.0 хувь нь хөдөө, орон нутагт байгааг дараах графикаас харж болно.

*Зураг 26. Боломжит ажиллах хүч, сургалтын төрөл, бүсээр*

Хэмжих нэгж: хувь



Нийт боломжит ажиллах хүчний 4.5 хувь нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байгаа, ур чадварт нь тохирох ажил байхгүй, туршлага байхгүй, ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу гэж үздэгийн улмаас итгэл алдарсан ажил хайгч байна. Тэдгээрийн 71.2 хувь нь эрэгтэй, 28.8 хувь нь эмэгтэйчүүд юм. Мөн 41.9 хувь нь ИДС төгсөгч, 58.1 хувь нь МБСБ төгсөгч байна.

Ажиллах хүчинээс гадуур /эдийн засгийн идэвхгүй/ болон ажилгүй байгаа төгсөгчдийн 88.5 хувь нь ажил хийгээгүй, дахин суралцаагүй залуучууд байгаагаас 20.0 хувь нь эрэгтэй, 80.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажил хийгээгүй болон дахин суралцаагүй залуучуудыг сургуулийн төрлөөр нь харахад 56.7 хувь нь ИДС төгсөгч, 43.3 хувь нь МБСБ төгсөгч байна.

#### Зураг 27. Ажил хийгээгүй болон дахин суралцаагүй залуучууд

Хэмжих нэгж: хувь



### 3.4. ТӨГСӨГЧДИЙН АЖЛЫН ТУРШЛАГА, ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### АЖЛЫН ТУРШЛАГА

Төгсөгчдийн 14.9 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд дунджаар хоёр ажлыг хийжээ. Сүүлийн нэг жилд ажил хийсэн төгсөгчдийн 54.8 хувь нь байнгын, 30.1 хувь нь түр, 8.8 хувь нь улирлын чанартай ажлын байранд ажиллаж байна. Сургуулийн төрлөөр нь харахад ИДС төгсөгчдийн 68.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 39.1 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байжээ. Харин МБСБ төгсөгчдийн 60.9 хувь нь түр болон улирлын чанартай ажлын байранд ажиллаж байна. Тухайн ажиллаж байсан ажлын байрандаа ИДС төгсөгчдийн 71.2 хувь гэрээтэй, МБСБ төгсөгчдийн 61.5 хувь нь гэрээгүй хөдөлмөр эрхэлж байжээ.

ИДС төгсөгчдийн хувьд ажлаас гарахад нөлөөлсөн гол хүчин зүйлс нь түр хугацааны ажлын байр, ар гэрийн асуудал, цалин хөлс бага байх, МБСБ төгсөгчдийн хувьд дээрх З хүчин зүйл дээр ажлаа солих сонирхол нэмэгдэж байв. Харин 5.7 хувь нь корона вирусээс болж ажлаас гарсан байна. Энэ тухай тайлангийн дараагийн хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Зураг 28. Ажиллаж байсан байгууллага, ажлаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлс

Хэмжих нэгж. хувь



Ажиллаж байсан байгууллага, ажлын байрны талаар төгсөгчдийн 19.4 хувь нь сэтгэл ханамжгүй, 80.6 хувь нь сэтгэл ханамжтай байснаа илэрхийлжээ.

Төгсөгчдийн ажиллаж байсан ажлын байранд гүйцэтгэж байгаа чиг үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцэл 48.2 хувь нь тохиромжтой, 51.8 хувь нь тохиромжгүй гэж дүгнэжээ. Сургуулийн төрлөөр тодруулбал, ИДС төгсөгчдийн 33.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 45.8 хувь нь эзэмшсэн мэргэжилтэйгээ огт тохиромжгүй ажлын байранд ажиллаж байсан гэв. МБСБ төгсөгчдийн хувьд ажлын чиг үүрэг, эзэмшсэн мэргэжил нь нийцгүй ажлын байранд ажиллаж байсан нь нэлээд өндөр байжээ.

Зураг 29. Ажиллаж байсан ажлын чиг үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцэл

Хэмжих нэгж. хувь нь



## ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нийт төгсөгчдөөс ирэх нэг жилийн төлөвлөгөө, эдийн засгийн идэвхийг тодруулсан. Төгсөгчдийн 47.9 хувь нь одоо хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийнэ гэсэн бол 11.5 хувь нь ажилд орох, 10.5 хувь нь гадаад, дотоодын сургуульд әлсэн суралцах, 6.9 хувь нь ажлаа өөрчлөх, 6.9 хувь нь тодорхой төлөвлөгөөгүй, 6.1 хувь нь хүүхэд асрах, гэрийн ажилд төвлөрөх зэрэг төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн.

Ажлаа өөрчлөх төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн 71.3 хувь албан байгууллагаа солих, 13.5 хувь нь байгууллага дотроо албан тушаалаа солих зэрэг шалтгаантай байна. Харин суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн 39.0 хувь нь дотоодын сургуульд әлсэн суралцах, 25.4 хувь нь магистр, докторт суралцах, 19.5 хувь нь гадаадад суралцах, 9.0 хувь нь үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй байна.

Цаашид төрөөс хөдөлмөр эрхлэхэд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар тодруулахад 15.9 хувь нь дэмжлэг туслалцаа хэрэгтүй, харин 13.9 хувь нь цалин нэмэх, илүү цагийн цалинг тооцох, 12.7 хувь нь ажлын байр нэмэгдүүлэх, 6.6 хувь нь зээлийн хүүг бууруулах, төсөл хөтөлбөрийн зээлд хамрагдах, 6.5 хувь нь сургалтад хамруулах, ажлын байрны дадлагажуулах сургалтууд, 5.0 хувь нь мэргэжлийн, тогтвортой ажлын байраар хангахад анхаарах шаардлагатай байгаагаа хэлсэн.

Зураг 30. Цаашид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар санал, хүсэлт

Хэмжих нэгж: хувь



## ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Корона вируст /covid-19/ цар тахал төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж буй талаар судлахыг зорилоо. Энэхүү судалгааны мэдээлэл цуглувалт 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 13 -ны өдрийн хооронд явагдсан. Тиймээс энэ хугацааны болон түүнээс өмнөх нөлөөлөл, өөрчлөлтийн талаарх мэдээллийг авсан болно. Өөрөөр хэлбэл дотоодод халдвартархсан 2020 оны 11 дүгээр сарын 13-аас хойших ямарваа нөлөөлөл манай судалгаанд тооцогдоогүй.

Судалгааны дүнгээс нийт төгсөгчдийн 45.7 хувь нь корона вируст /covid-19/ цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, өрхийн орлого, цалин хөлс гэх мэтэд ямар нэг өөрчлөлт гараагүй гэж хариулсныг харж болно. Харин төгсөгчдийн 22.4 хувь нь цалин, орлого буурсан, санхүүгийн хүндрэл үүссэн, 7.6 хувь нь сургууль, цэцэрлэг ажиллахгүйгээс болж хүүхэд харах хүнгүй ажил хийх боломжгүй болсон зэрэг хүндрэл тохиолдсоныг дурджээ.

Зураг 31. Цар тахлын нөлөө


Хэмжих нэгж: хувь



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөд корона вируст цар тахал хэрхэн нөлөөлж буй талаар тодруулахад 24.8 хувь нь өрхийн орлого буурсан, 22.9 хувь нь ажлын цаг багассан, 19.3 хувь нь цалин буурсан, 13.0 хувь нь борлуулалтын орлого буурсан гэж хариулсан.

Зураг 32. Хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь



Хүйсийн хувьд хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй төгсөгчдийн 23.2 хувь нь өрхийн болон бизнесийн орлого буурсан, 22.7 хувь нь ажлын цаг багассан, 21.0 хувь нь цалин буурсан гэсэн бол эмэгтэйчүүдийн хувьд 26.4 өрхийн орлого бизнесийн орлого буурсан, 23.2 хувь нь ажлын цаг багассан, 17.5 хувь нь цалин буурсан 15.6 хувь нь борлуулалтын орлого буурсан гэж хариулжээ.

Боловсролын салбарт ажиллаж байгаа төгсөгчдийн 36.4 хувийн ажлын цаг багассан, 24.0 хувийн цалин буурсан бол ХАА-н салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 37.5 хувийн өрхийн болон бизнесийн орлого буурсан, 20.7 хувийн борлуулалтын орлого буурчээ. Харин ус хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй 5 төгсөгч тутмын 2 нь өрхийн болон бизнесийн орлого буурсан, мөн санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд ажлын цаг нь багассан, цалин нь буурсан үзүүлэлттэй байна.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 43.2 хувьд цалингүй чөлөө олгосон, 44.0 хувийн ажлын цагийг багассан бол удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй 5 төгсөгч тутмын 4-д цалин буурсан нөлөө үзүүлсэн байна.

#### Хүснэгт 15. Хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, ЭЗҮА-ны салбар, хувиар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Цалингүй чөлөө олгосон	Ажлын цаг багассан	Цалин буурсан	Өрхийн болон бизнесийн орлого буурсан	Гэр булийн хүн ажилүй болсон	Ажилчдаа томхогсон	Хувийн бизнесийн үйл ажиллагаа зогссон	Борлуулалтын орлого буурсан	Бүлд
Боловсрол	3.6	36.4	24.0	15.8	5.1	2.9	3.9	8.3	100
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6.5	12.1	11.9	37.5	4.1	3.9	3.2	20.7	100
Уул уурхай, олборлолт	9.0	15.6	23.3	26.6	2.2	11.1	4.8	7.4	100
Боловсруулах үйлдвэрлэл	3.2	22.7	16.7	23.0	3.4	8.4	6.3	16.3	100
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5.7	27.8	11.1	24.2	3.7	3.8	14.5	9.3	100
Ус хангамж бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.3	15.8	24.7	43.5	8.8	3.5	0.0	3.5	100
Барилга	7.7	19.6	20.4	22.6	7.0	6.1	3.7	12.9	100
Бөөний болон жижиглэн худалдаа	7.4	12.3	20.5	35.3	4.2	2.7	6.4	11.2	100
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.5	22.0	23.8	22.7	5.6	4.6	1.6	14.0	100
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.0	17.0	13.5	31.1	1.6	4.6	0.0	28.2	100
Мэдээлэл, холбоо	2.4	21.8	22.5	27.6	1.7	3.9	4.0	16.2	100
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	7.8	35.1	24.4	13.3	8.2	1.3	0.2	9.6	100
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	43.2	44.0	12.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	100
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.5	31.5	13.2	19.3	4.0	0.6	14.9	14.1	100
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.0	0.0	84.3	15.7	0.0	0.0	0.0	0.0	100


## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	8.5	27.0	15.4	27.0	1.0	7.4	2.6	11.1	100
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.6	27.7	12.1	24.6	12.7	4.1	1.0	15.2	100
Үрлаг, үзэр, тоглоом наадам	14.2	33.6	18.3	11.2	0.0	2.9	11.2	8.5	100
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9.1	19.0	20.2	20.4	3.3	3.4	4.8	19.8	100
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	100

Ажилгүй болон эдийн засгийн идэвхгүй байгаа төгсөгчдийн 56.6 хувьд нь цар тахлын нөлөө байгаагүй гэж үзэж болохоор байна. Харин 10.5 хувь нь ажлын байр багассан, цомхотгол хийсэн, 7.8 хувь нь ажил олдоогүй, ажилд ороход хүндрэлтэй байна, 6.2 хувь нь хөл хорионд орсон, хөл хорионоос болж ажил хийх, ажил хайх боломжгүй байгаа, 5.6 хувь нь ажил зогссон, сүл зогсолт хийсэн зэрэг шалтгаан нэрлэжээ.

Зураг 33. Ажлын байр хайх, ажилд ороход цар тахал нөлөөлсөн эсэх

Хэмжих нэгж: хувь



IV

БҮЛЭГ  
ТӨГСӨГЧДИЙН  
ХӨДӨЛМӨРИЙН  
ЗАХ ЗЭЭЛ ДЭХ  
ХӨДӨЛГӨӨН

#### 4.1. Төгсөгчдийн 4 жилийн эдийн засгийн идэвх

Судалгааны энэ бүлэгт төгсөгчдийн сүүлийн 4 жилийн эдийн засгийн идэвх, түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулахыг зорилоо. Мэргэжлийн дагуу ажил, хөдөлмөр эрхэлж чадаж байгаа эсэх, сонгон ажиллаж байгаа ажил нь эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшинд нь тохирч байгаа эсэх, мөн ажилд орсны дараа сургуульд эзэмшсэн мэдлэг, чадвар нь ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх гэх мэт асуудлууд зөвхөн төгсөгчид төдийгүй боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан бодлого боловсруулагчдын анхаарлын төвд байдаг.

Үүний учир шалтгааныг тодруулах зорилгоор 2015-2016 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийг 4 жил дараалан мөшгөн, хувь хүний түвшинд ямар өөрчлөлт гарсныг нарийвчлан судаллаа. Сургуулиа төгссөнөөс хойш дөрвөн жилийн хугацаанд төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг энэ бүлэгт харууллаа.

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт төгсөгчдийн 70.6 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна. Сургуулийн төрлөөр ИДС төгсөгчдийн 75.0 хувь нь, МБСБ төгсөгчдийн 63.6 хувь нь хөдөлмөр эрхэлсэн ба харин МБСБ төгсөгчдийн 12.5 хувь нь, ИДС төгсөгчдийн 7.0 хувь нь ажилгүй байжээ. Мөн МБСБ төгсөгчдийн 23.9 хувь эдийн засгийн идэвхгүй байна.

Хүснэгт 16. 4 жилийн эдийн засгийн идэвх, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Сургуулийн төрөл		Нийт
	ИДС	МБСБ	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2017	68.4	49.0	60.9
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2018	75.2	62.4	70.2
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2019	79.5	71.6	76.5
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	76.9	71.5	74.8
<b>Дундаж түвшин</b>	<b>75.0</b>	<b>63.6</b>	<b>70.6</b>
<b>Ажилгүйдэл</b>			
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2017	12.2	22.9	16.3
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2018	9.2	16.8	12.1
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2019	2.5	5.2	3.6
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2020	4.0	5.2	4.5
<b>Дундаж түвшин</b>	<b>7.0</b>	<b>12.5</b>	<b>9.1</b>
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2017	19.3	28.2	22.8
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2018	15.6	20.9	17.7
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2019	17.9	23.1	19.9
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2020	19.1	23.3	20.7
<b>Дундаж түвшин</b>	<b>18.0</b>	<b>23.9</b>	<b>20.3</b>

Сүүлийн 4 жилд дунджаар эрэгтэй төгсөгчдийн 80.3 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 63.6 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна. Мөн эмэгтэй төгсөгчдийн

## БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

8.4 хувь нь, эрэгтэй төгсөгчдийн 10.7 хувь нь ажилгүй байсан бол эдийн засгийн идэвхгүй байсан 24.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэй төгсөгчдийн хувьд хөдөлмөр эрхлэлт бага, эдийн засгийн идэвхгүй байгаа нь нөхөн үргижүйн насны онцлогоос хамаарч, хүүхэд төрүүлэх, асрах шалтгааны улмаас эдийн засгийн үйл ажиллагааны оролцоонд тодорхой хязгаарлалтууд үүсдэг болохыг ялгаж ойлгох зүйтэй юм.

**Хүснэгт 17. 4 жилийн эдийн засгийн идэвх, хүйсээр**

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2017	66.8	56.7	60.9
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2018	79.7	63.5	70.2
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2019	88.0	68.2	76.5
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	86.9	66.1	74.8
<b>Дундаж</b>	<b>80.3</b>	<b>63.6</b>	<b>70.6</b>
<b>Ажилгүйдэл</b>			
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2017	18.3	18.1	16.3
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2018	9.9	13.7	12.1
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2019	2.5	5.2	3.6
Ажилгүйдлийн цэвэр түвшин, %, 2020	2.7	5.7	4.5
<b>Дундаж</b>	<b>8.4</b>	<b>10.7</b>	<b>9.1</b>
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2017	14.9	25.2	22.8
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2018	10.6	22.6	17.7
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2019	17.9	23.1	19.9
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, %, 2020	10.4	28.2	20.7
<b>Дундаж</b>	<b>13.4</b>	<b>24.8</b>	<b>20.3</b>

## 4.2. ДӨРВӨН ЖИЛ ТАСРАЛТГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ТӨГСӨГЧДИЙН ТӨЛӨВ

Хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 45.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 38.5 хувь нь 2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлж байна. ИДС төгсөгчдийн 74.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 55.3 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлсэн байна. Дөрвөн жил тогтвортой хөдөлмөр эрхэлж буй анагаах ухаан, урлаг, багш, боловсрол судлал, мал эмнэлэг, барилга, архитектур, үйлдвэрлэлийн технологи, тээвэр зэрэг мэргэжлийн чиглэлээр төгссөн 5 төгсөгч тутмын 4 нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлжээ. Харин байгаль хамгаалал, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, нийгэм, эдийн засаг, компьютер, биологи, нийгмийн халамж, хангамжийн мэргэжил эзэмшин 2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн 10 төгсөгч тутмын 4-5 нь мэргэжлийн бус ажил хийж байна.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 34. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн ИДС төгсөгчид, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



■ Тохиромжтой ■ Тохиромжгүй

4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн МБСБ төгсөгчдөөс 70-с дээш хувь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлсэн нь эрүүл мэнд, үйлчилгээ, эрчим хүчиний чиглэлээр төгсөгчид байна. Харин ХАА, мэдээллийн технологи, барилгын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн тэн хагас нь мэргэжлийн бус ажил хийсэн байна.

Зураг 35. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн МБСБ төгсөгчид, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



■ Тохиромжтой ■ Тохиромжгүй

## БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

---

2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 85.7 хувь нь гэрээ байгуулан ажиллаж байна. Тэдгээрийг ажиллаж буй ЭЗҮА-ны салбараар харахад салбар бүрт 80 ба түүнээс дээш хувь нь гэрээ байгуулан ажиллаж байна. Цахилгаан, хий, уур, агааржуулалт, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт тогтвортой ажиллаж буй төгсөгчид бүгд гэрээ байгуулан ажиллажээ.

Дөрвөн жилийн хугацаанд хөдөлмөр эрхэлсэн боловсролын салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 90.9 хувь нь, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 88.9 хувь нь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 86.6 хувь нь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 84.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Харин бөөний болон жижиглэн худалдаа: машин мотоциклын засвар үйлчилгээ, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агуулур, мэдээлэл, холбоо, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж буй 10 төгсөгч тутмын 5 нь мэргэжлээрээ ажиллахгүй байна.

**Зураг 36. 4 жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдид, ЭЗҮА-ны салбараар**

Хэмжих нэгж: хувь



■ Тохиромжтой ■ Тохиромжгүй

#### **4.3. 2017 БА 2019 ОНООС ХОЙШ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ШИЛЖИЛТ ХИЙСЭН БАЙДАЛ**

Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх хөдөлгөөнийг судалгаа эхэлсэн 2017 оноос авч үзье. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 81.5 хувь нь 2020 онд хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 18.5 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн 7.0 хувь нь ажилгүй хэвээр буюу урт хугацааны ажилгүйдэлд өртсөн бөгөөд 66.7 хувьд нь ээрэг, 26.2 хувьд нь сөрөг өөрчлөлт гарчээ. Харин эдийн засгийн идэвхгүй байсан төгсөгчдийн 30.4 хувь нь ЭЗИ-гүй хэвээр байгаа бол 69.6 хувь нь ЭЗИ-ийн ээрэг өөрчлөлт гарсан байна. Энэ үзүүлэлтийг хүйсээр харвал эрэгтэй төгсөгчдийн 64.6 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 41.7 хувь нь ажилтай хэвээр байна. Эмэгтэйчүүд дунд эдийн засгийн идэвхгүй төлөв илуу ажиглагдаж байгаа нь жирэмсэн, хүүхэд асрах шалтгаантай шууд холбоотой байж болох юм.

Хүснэгт 18. 2017 оноос хойш ЭЗ-ийн идэвхэд шилжилт хийсэн байдал, хүйсээр

Хэмжих нэгж: хувь


2017 оны үеийн хүн ам зүйн шинж байдал	Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд 2017-2020 онд гарсан хөдөлгөөнүүд					Бүгд
	ЭЗИ хэвээр, ажилтай	ЭЗИ хэвээр, ажилгүй	ЭЗИ хэвээр, ЭЗ-ийн идэвхгүй	ЭЗИ-д эерэг өөрчлөлт гарсан	ЭЗИ-д сөрөг өөрчлөлт гарсан	
<b>Эдийн засгийн идэвх</b>						
Хөдөлмөр эрхэлж буй	80.8	0.0	0.0	0.0	19.2	100.0
Ажилгүй	0.0	6.7	0.0	67.3	26.0	100.0
Эдийн засгийн идэвхгүй	0.0	0.0	30.6	69.4	0.0	100.0
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	62.8	0.7	2.1	25.1	9.3	100.0
Эмэгтэй	41.4	1.3	10.1	26.4	20.9	100.0

Бүсээр нь авч үзвэл нийслэлд оршин сууж байсан төгсөгчдийн 54.5 хувь нь ажилтай хэвээр байгаа бол бусад бүсийн төгсөгчдийн 50.0 ба түүнээс доош хувь нь ажилтай хэвээр байна. Эдийн засгийн идэвхэд хамгийн их өөрчлөлт гарсан нь баруун бүсэд амьдарч буй төгсөгчид байна.

2017 оноос хойш эдийн засгийн идэвхэд гарсан шилжилтийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр хараад барилга, архитектурын мэргэжлээр төгсөгчдийн 79.2 хувь нь 2020 онд хөдөлмөр эрхэлж буй хэвээр байгаа нь бусад мэргэжилтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн хувь өндөр байна. Мөн хүмүүнлэгийн болон анагаах ухаан, биологи, багш, боловсрол судлал мэргэжлээр төгсөгчдийн эдийн засгийн идэвх бусад төгсөгчидтэй харьцуулахад буурсан дүнтэй байна.

## БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

**Зураг 37. 2017 оноос хойш ЭЗИ-д шилжилт хийсэн байдал, ИДС-н мэргэжлийн чиглэлээр**



МБСБ төгсөгчдийг 2017 оноос хойш эдийн засгийн идэвхэд шилжилт хийсэн байдлыг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр хараад өрүүл мэндийн салбарын мэргэжлээр төгсөгчдийн 59.6 хувь нь хөдөлмөр өрхэлсэн хэвээрээ байгаа нь бусад мэргэжлүүдтэй харьцуулахад өндөр байна. Мөн төгссөнөөсөө хойш ажилгүйдэлд хамгийн их өртсөн нь боловсрол, үйлчилгээ, ХАА-н салбарын мэргэжлээр төгсөгчид байгаа юм. Төгссөнөөсөө хойш 4 жилийн хугацаанд эдийн засгийн идэвхэд өөрчлөлт их орсон мэргэжлийн чиглэлүүдэд ХАА, байгаль орчин, аялал жуулчлал, мэдээллийн технологи, соёл, урлаг, эрчим хүч, боловсрол, үйлчилгээний салбар зэрэг байна.

**Зураг 38. 2017 оноос хойш ЭЗИ-д шилжилт хийсэн байдал, МБСБ-н мэргэжлийн чиглэлээр**



## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Тайлангийн энэ хэсэгт сүүлийн хоёр оны эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлтийг харьцуулан харуулах болно. Өөрөөр хэлбэл, төгсөгчдийн 2019 оны хүн ам зүй, эдийн засгийн идэвх 2020 онд хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлах юм. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 84.7 хувь нь 2020 онд хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 15.3 хувь нь эдийн засгийн идэвхгүй эсвэл ажилгүй болсон байна. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн 13.8 хувь нь ажилгүй хэвээр урт хугацааны ажилгүйдэлд өртсөн бол 47.6 хувьд нь эерэг, 38.5 хувьд нь сөрөг эдийн засгийн идэвхийн өөрчлөлт гарчээ. Харин эдийн засгийн идэвхгүй байсан төгсөгчдийн 46.0 хувь нь ЭЗИ-гүй хэвээр байгаа бол 54.0 хувь нь ЭЗИ-ийн эерэг өөрчлөлт гарсан байна.

Хүйсийн хувьд эрэгтэй төгсөгчдийн 81.1 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 53.4 хувь нь хөдөлмөр эрхэлж буй хэвээр. Мөн эмэгтэйчүүдийн 14.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй хэвээр, 15.7 хувь нь ЭЗИ-д нь эерэг өөрчлөлт гарсан байна.

Бүсээр нь харахад Улаанбаатар, Хангайн, Төв, Зүүн бүсийн гурван төгсөгч тутмын хоёр нь хөдөлмөр эрхэлж буй хэвээрээ буюу харьцангуй тогтвортой хөдөлмөр эрхэлж байна. Харин эдийн засгийн идэвхэд нь хамгийн их өөрчлөлт гарсан нь Баруун бүсэд амьдарч буй төгсөгчид байна.

Хүснэгт 19. 2019 оноос хойш ЭЗ-ийн идэвхийн шилжилт, шинж байдлаар, хувиар

2019 оны үеийн хүн ам зүйн шинж байдал	Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд 2019-2020 онд гарсан хөдөлгөөнүүд					Бүгд
	ЭЗИ хэвээр, ажилтай	ЭЗИ хэвээр, ажилгүй	ЭЗИ хэвээр, ЭЗ-ийн идэвхгүй	ЭЗИ-д эерэг өөрчлөлт гарсан	ЭЗИ-д сорог өөрчлөлт гарсан	
<b>Эдийн засгийн идэвх</b>						
Ажилтай	84.7	0.0	0.0	0.0	15.3	100.0
Ажилгүй	0.0	13.8	0.0	47.6	38.5	100.0
Эдийн засгийн идэвхгүй	0.0	0.0	46.0	54.0	0.0	100.0
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	81.1	0.4	2.6	7.8	8.0	100.0
Эмэгтэй	53.4	0.4	14.1	15.7	16.4	100.0
<b>Амьдарч буй бүс</b>						
Улаанбаатар	67.1	0.3	9.4	10.6	12.5	100.0
Баруун	46.4	0.9	9.4	24.5	18.8	100.0
Хангай	64.9	0.9	7.1	13.7	13.4	100.0
Төв	66.5	0.3	10.0	12.3	10.9	100.0
Зүүн	67.3	0.1	10.9	9.9	11.9	100.0

МБСБ төгсөгчдийн 2019 оноос эдийн засгийн идэвхэд шилжилт хийсэн байдлыг эзэмшсэн мэргэжлээр харахад дараах байдалтай байна. Үүнд тээврийн салбарын төгсөгчдийн 70.4 хувь нь ажилтай хэвээрээ байгаа нь бусад мэргэжлийн төгсөгчидтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлт өндөр байна. Мөн уул уурхай, барилга, эрчим хүч, эрүүл мэндийн салбарын төгсөгчдийн 63.5-69.9 хувь нь ажилтай хэвээр. Сүүлийн 2 жилийн хугацаанд эдийн засгийн идэвх нь хамгийн ихээр нэмэгдсэн мэргэжлийн чиглэлүүдэд ХАА, соёл урлаг, байгаль орчин,

## БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

аялал жуулчлал зэрэг байгаа бол эдийн засгийн идэвх нь хамгийн их буурсан нь боловсрол, санхүү, бизнес, худалдаа, үйлчилгээний салбарын мэргэжлээр төгсөгчид байна.

**Зураг 39. 2019 оноос хойш ЭЗИ-ийн шилжилт, МБСБ-ийн мэргэжлийн чиглэлээр**

**Хэмжих нэгж: хувь**




2019 оноос хойш эдийн засгийн идэвхэд шилжилт хийсэн байдлыг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр хараад барилга, архитектурын мэргэжлээр төгсөгчдийн 87.1 хувь нь, тээврийн мэргэжлийн төгсөгчдийн 86.8 хувь нь, физик, хими, геологи, газар зүйн мэргэжлийн 81.9 хувь нь, хууль эрх зүйн 81.0 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд ажилтай хэвээр байгаа нь бусадтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байна.

Харин анагаах ухаан, нийгмийн халамж, хангамж, бизнес, удирдлага зэрэг мэргэжлээр төгсөгчдийн эдийн засгийн идэвх бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад илүү нэмэгдсэн бол багш боловсрол судлал, байгаль хамгаалал, нийгэм, эдийн засаг, математик, статистикийн мэргэжлээр төгсөгчдийн эдийн засгийн идэвх буурчээ.

Зураг 40. 2019 оноос хойш ЭЗИ-ийн шилжилт, ИДС-н мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



■ Ажилтай хэвээр

■ ЭЗИйн төлөв сайжирсан

■ Ажилгүй хэвээр

■ ЭЗИйн төлөв дордсон

V

БҮЛЭГ

ТӨГСӨГЧДИЙН  
2017, 2020 ОНЫ  
ХӨДӨЛМӨРИЙН  
ЗАХ ЗЭЭЛ ДЭХ  
ХӨДӨЛГӨӨН

Судалгааны энэ бүлэгт төгсөгчдийн 2017 болон 2020 оны эдийн засгийн идэвх, түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг харьцуулан харуулахыг зорилоо. Өөрөөр хэлбэл хоёр оны хөдөлмөрийн зах зээлд гарсан нийт өөрчлөлт, хөдөлгөөнийг бүхэлд нь өсөн нэмэгдсэн дүнгээр, ерөнхий цар хүрээгээр зураглан харуулах юм. Төгсөгчдийн эдийн идэвхэд гарсан өөрчлөлтийг судалгааны эхний жил буюу 2017 оныг сүүлийн жил болох 2020 онтой харьцуулж үр дүнг тооцлоо.

### **5.1. НИЙТ ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

Судалгааны эхний жил буюу 2017 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 60.9 хувь байсан бол 2020 онд 74.8 хувь болж 13.9 пунктээр нэмэгдсэн байна. Үүнийг сургуулийн төрлөөр нь авч үзвэл хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин ИДС төгсөгчдийн хувьд 8.5 пунктээр, МБСБ төгсөгчдийн хувьд 22.5 пунктээр нэмэгджээ. Мөн 2020 онд ажилгүйдэл 11.8 пунктээр буурсан ба энэ үзүүлэлт ИДС төгсөгчдийн хувьд 8.2, МБСБ төгсөгчдийн хувьд 17.7 пунктээр тус тус буурчээ.

2017 онд ажилгүй эсвэл эдийн засгийн идэвхгүй байсан төгсөгчдийн 24.4 хувь нь ажилтай болсон бөгөөд сургуулийн төрлөөр харвал ИДС төгсөгчдийн 19.8 хувь, МБСБ төгсөгчдийн 31.9 хувь нь ажилтай болжээ. Харин 2017 онд ажилтай байсан ИДС төгсөгчдийн 12.8 хувь, МБСБ төгсөгчдийн 10.5 хувь нь ажилгүйдэлд өртсөн болон ажиллах хүчинээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжсэн байна. ИДС төгсөгчдийн 32.6 хувь нь, МБСБ төгсөгчдийн 42.4 хувь нь ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон буюу судалгааны 2 жилийн аль нэгэнд нь хөдөлмөр эрхэлсэн байна. МБСБ төгсөгчдийн эдийн засгийн идэвх сүүлийн жилүүдэд илүү нэмэгдсэн ч ажлын байрны тогтвортгүй байдал ажиглагдаж байгаа нь эзэмшсэн мэргэжлийн онцлогтой холбоотой байж болох юм.

Нийт төгсөгчдийн 86.8 хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцон хөдөлмөр эрхэлсэн туршлагатай байна. Нарийвчилбал, ИДС төгсөгчдийн 89.7 хувь, МБСБ төгсөгчдийн 82.1 хувь нь төгссөнөөсөө хойш ямар нэг байдлаар хөдөлмөр эрхэлж ажлын туршлагаа нэмэгдүүлжээ. Харин ИДС төгсөгчдийн 15.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 25.4 хувь нь судалгааны 2 жилийн аль нэгэнд нь ажилгүй, мөн ИДС төгсөгчдийн 31.8, МБСБ төгсөгчдийн 42.7 хувь нь 2 жилийн аль нэг хугацаанд эдийн засгийн идэвхгүй төлөвт байжээ.

**Хүснэгт 20. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн цэвэр ба бохир үзүүлэлтүүд, 2017, 2019 он, сургуулийн төрлөөр**

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Сургуулийн төрөл		Нийт
	ИДС	МБСБ	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2017	68.4	49.0	60.9
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	76.9	71.5	74.8
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр өөрчлөлт, %, 2017-2020	8.5	22.5	13.9
Үүнд: 2020 онд ажилтай болсон хувь	19.8	31.9	24.4
2020 онд ажлаас гарсан хувь	12.8	10.5	11.9
Ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон нийт төгсөгчдийн хувь, %, 2017-2020	32.6	42.4	36.4
Хөдөлмөр эрхлэлтийн бохир түвшин, 2017-2020	89.7	82.1	86.8

**Ажилгүйдэл**

## БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧДИЙН 2017, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2017	12.2	22.9	16.3
Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2020	4.0	5.2	4.5
Ажилгүйдлийн түвшний цэвэр өөрчлөлт, % 2017-2020	-8.2	-17.7	-11.8
Үүнд: 2017 оноос хойш шинээр ажилгүй болсон хувь	3.2	3.8	3.4
2017 оноос хойш ажилгүйдлээс гарсан хувь	11.1	20.2	14.6
Ажилгүйдлийн бохир түвшин, %, 2017-2020	15.1	25.4	19.1
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2017	19.3	28.2	22.8
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2020	19.1	23.3	20.7
Эдийн засгийн идэвхгүй түвшний цэвэр өөрчлөлт, % 2017-2020	-0.2	-4.9	-2.1
Үүнд: 2017 оноос хойш шинээр эз-ийн идэвхгүй болсон %	13.7	14.5	14.0
2017 оноос хойш эз-ийн идэвхгүй байдлаас гарсан %	12.7	19.4	15.3
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн бохир түвшин, 2017-2020	31.8	42.7	36.0

2017, 2020 оны судалгааны үр дүнг харьцуулахад төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 13.9 хувиар өссөн, ажилгүйдлийн түвшин 11.8 хувиар буурсан мэт боловч бодит хөдөлмөрийн зах зээлд илүү хэмжээний эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хөдөлгөөнүүд төгсөгчдийн дунд гарсан байна. Тухайлбал, нийт төгсөгчдийн 86.8 хувь нь 2017, 2020 онд ямар нэгэн байдлаар ажил эрхэлсэн байгаа ба тэдний зарим нь судалгаа авах 2 жилд хоёуланд ажилтай байсан, зарим нь аль нэг жилд нь л ажиллаж, бусад үед нь ажилгүй юм уу эдийн засгийн идэвхгүй төлөвт байсан байна.

Нийт төгсөгчдийн 19.1 хувь нь 2017, 2020 онд ямар нэг байдлаар ажилгүйдэлд өртсөн ба зарим нь тухайн 2 жилд ажилгүй байсан байхад зарим нь ажилтай эсвэл эдийн засгийн идэвхгүй гэсэн төлөвүүд хооронд шилжин, хөдөлгөөнтэй байсан. Эдгээр хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн өөрчлөлт, хөдөлгөөн төгсөгчдийн хувьд хэр өргөн хүрээг хамарсан байгааг Хүснэгт 18-д дэлгэрэнгүй харуулав.

Судалгааны эхний жил болох 2017 оныг 2020 онтой харьцуулан хараад төгсөгчдийн 58.2 хувийн эдийн засгийн идэвх өөрчлөгдөөгүй. Үүнийг сургуулийн төрлөөр ангилбал ИДС төгсөгчдийн 63.4 хувь, МБСБ төгсөгчдийн 49.9 хувийн эдийн засгийн идэвх хэвээр байна. Эдийн засгийн идэвхийн төлөв нь өөрчлөгдөөгүй төгсөгчдийг нарийвчлан үзвэл ИДС төгсөгчдийн 57.1 хувь нь хөдөлмөр эрхэлж, 0.8 хувь нь ажилгүй, 5.4 хувь нь ажиллах хүчинээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй хэвээр, МБСБ төгсөгчдийн 39.7 хувь нь хөдөлмөр эрхэлж, 1.4 хувь нь ажилгүй, 8.8 хувь нь эдийн засгийн идэвхгүй хэвээр буюу төлөв нь өөрчлөгдөөгүй байна. 2017, 2020 онд эдийн засгийн идэвхэд ИДС төгсөгчдийн 20.9 хувьд нь, МБСБ төгсөгчдийн 33.7 хувьд нь зэрэг өөрчлөлт гарчээ.

**Хүснэгт 21. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр**

Хэмжих нэгж: хувь

Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд 2017, 2020 онд гарсан хөдөлгөөнүүд	Сургуулийн төрөл		Нийт
	ИДС	МБСБ	
Эдийн засгийн идэвх нь өөрчлөгдоогүй	63.4	49.9	58.2
Хөдөлмөр эрхэлдэг эрхэлдэг хэвээр	57.1	39.7	50.4
Ажилгүй хэвээр	0.8	1.4	1.0
Эдийн засгийн идэвхгүй хэвээр	5.4	8.8	6.7
Эдийн засгийн идэвхэд зэрэг өөрчлөлт гарсан	20.9	33.7	25.8
Эдийн засгийн идэвхгүйгээс ажилгүйд шилжсэн	1.1	1.8	1.4

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Эдийн засгийн идэвхгүйгээс хөдөлмөр эрхэлдэгт шилжсэн	11.6	17.6	13.9
Ажилгүйгээс хөдөлмөр эрхэлдэгт шилжсэн	8.2	14.3	10.6
<b>Эдийн засгийн идэвхэд сорог өөрчлөлт гарсан</b>	<b>15.7</b>	<b>16.4</b>	<b>16.0</b>
Хөдөлмөр эрхэлдгээс ажилгүй төлөвт шилжсэн	2.1	2.0	2.0
Хөдөлмөр эрхэлдгээс эдийн засгийн идэвхгүйд шилжсэн	10.7	8.6	9.9
Ажилгүйгээс эдийн засгийн идэвхгүйд шилжсэн	2.9	5.9	4.1
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>

Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн бохир түвшинг хүйсээр харахад эрэгтэй төгсөгчдийн 92.9 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 82.3 хувь нь хөдөлмөр эрхэлжээ. Мөн эрэгтэйчүүдийн 17.2 хувь нь, эмэгтэйчүүдийн 20.5 хувь нь ажилгүй байж үзсэн, эрэгтэйчүүдийн 24.2 хувь нь, эмэгтэйчүүдийн 44.5 хувь нь эдийн засгийн идэвхгүй байж үзсэн бол эрэгтэй төгсөгчдийн 30.2 хувь, эмэгтэйчүүдийн 40.9 хувь ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон байна.

2017 онтой харьцуулахад эрэгтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 18.5 пунктээр, эмэгтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 17.1 пунктээр нэмэгдсэн. Мөн ажилгүй эрэгтэйчүүд 9.5 пунктээр, эмэгтэйчүүд 17.2 пунктээр буурсан харагдаж байна. Дэлгэрэнгүйг хүснэгт 19-т харууллаа.

**Хүснэгт 22. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн цэвэр ба бохир үзүүлэлтүүд, 2017, 2020 он, хүйсээр**

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2017	68.4	49.0	60.9
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	86.9	66.1	74.8
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр өөрчлөлт, %, 2017-2020	18.5	17.1	13.9
Үүнд: 2020 онд ажилтай болсон хувь	24.1	24.7	24.4
2020 онд ажлаас гарсан хувь	6.0	16.2	11.9
Ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон нийт төгсөгчдийн хувь, %, 2017-2020	30.2	40.9	36.4
Хөдөлмөр эрхлэлтийн бохир түвшин, 2017-2020	92.9	82.3	86.8
<b>Ажилгүйдэл</b>			
Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2017	12.2	22.9	16.3
Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2020	2.7	5.7	4.5
Ажилгүйдлийн түвшний цэвэр өөрчлөлт, % 2017-2020	-9.5	-17.2	-11.8
Үүнд: 2017 оноос хойш шинээр ажилгүй болсон хувь	2.0	4.5	3.4
2017 оноос хойш ажилгүйдлээс гарсан хувь	14.5	14.7	14.6
Ажилгүйдлийн бохир түвшин, %, 2017-2020	17.2	20.5	19.1
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2017	19.3	28.2	22.8
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2020	10.4	28.2	20.7
Эдийн засгийн идэвхгүй түвшний цэвэр өөрчлөлт, % 2017-2020	-8.9	0.0	-2.1
Үүнд: 2017 оноос хойш шинээр эз-ийн идэвхгүй болсон %	8.3	18.1	14.0
2017 оноос хойш эз-ийн идэвхгүй байдлаас гарсан %	13.9	16.3	15.3
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн бохир түвшин, 2017-2020	24.2	44.5	36.0

## 5.2. 2017 ОНД АЖИЛТАЙ БАЙСАН ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Судалгааны эхний жил /2017 онд/ хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 80.8 хувь нь 2020 онд хөдөлмөр эрхэлсэн хэвээр буюу хөдөлмөрийн зах зээлд тогтвортой байна. Харин тэдний 3.3 хувь нь ажилгүй, 15.9 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжжээ. Сургуулийн төрлөөр үзвэл ИДС төгсөгчдийн 81.7 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 18.3 хувь нь эдийн засгийн идэвхийн шилжилт хийсэн байна. Харин МБСБ төгсөгчдийн 79.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 3.9 хувь нь ажлаасаа гарсан, 17.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна.

Зураг 41. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хувиар



ЭЗҮА-ны салбараар нь 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан гол өөрчлөлт ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, үйлчилгээний салбарт ажиллаж байсан төгсөгчдийн дунд ажиглагдсан ба 26.7-28.0 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжжээ. Мөн үл хөдлөхийн үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 30.7 хувь нь, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 6.0 хувь нь ажилгүй болжээ. Харин барилга, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдөд өөрчлөлт бага гарсан байна.

Хүснэгт 23. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар

Хэмжих нэгж: хувь

2017 онд ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2020 оны ЭЗИ-ийн толов			Бүгд
	Ажилтай хэвээр	Ажилгүй болсон	ЭЗ идэвхгүй болсон	
Барилга	93.3	2.0	4.7	100.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	90.2	2.0	7.8	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	86.8	0.0	13.2	100.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	86.8	0.0	13.2	100.0
ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	84.7	0.0	15.3	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	84.2	4.7	11.1	100.0
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	83.9	0.0	16.1	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа	82.8	3.8	13.4	100.0

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Уул уурхай, олборлолт	82.4	3.7	13.8	100.0
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	82.4	0.0	17.6	100.0
Мэдээлэл, холбоо	81.4	2.8	15.8	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	81.3	2.1	16.7	100.0
Боловсрол	79.8	3.3	16.8	100.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	78.5	2.4	19.2	100.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж	76.0	3.8	20.2	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	73.5	4.3	22.3	100.0
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	72.0	0.0	28.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	69.3	30.7	0.0	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	68.0	5.2	26.7	100.0
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	67.1	6.0	26.9	100.0
<b>Бүгд</b>	<b>80.8</b>	<b>3.3</b>	<b>15.9</b>	<b>100.0</b>

Төгсөгчдийг 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь харахад дотоод, гадаадын, хамтарсан хөрөнгө оруулалттай компанийд ажиллаж байсан төгсөгчдийн 79.9 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр байгаа бол 3.7 хувь нь ажилгүй, 16.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй болсон. Харин төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллаж байсан төгсөгчдийн 97.3 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр байна. ТББ, тусгай сан, нийгэмлэг, ОУБ, бусад салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 25.0 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна.

Хүснэгт 24. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ажиллаж байсан байгууллагын өмчийн хэлбэрээр

Хэмжих нэгж: хувь

2017 онд ажиллаж байсан байгууллагын өмчийн хэлбэр	2020 оны ЭЗИ-ийн төлөв			Бүгд
	Ажилтай хэвээр	Ажилгүй болсон	ЭЗ идэвхгүй болсон	
Дотоодын/гадаадын/хамтарсан хөрөнгө оруулалттай компани	79.9	3.7	16.4	100.0
Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллага	82.4	3.2	14.4	100.0
Төрийн өмчит үйлдвэр	97.3	0.0	2.7	100.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	78.7	1.3	20.0	100.0
ТББ, тусгай сан, нийгэмлэг, ОУБ, бусад	73.2	1.8	25.0	100.0

Эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 82.9 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 2.6 хувь нь ажилгүй болсон, 14.5 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжсэн байна. Харин мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 76.7 хувь нь ажилтай хэвээр, 4.6 хувь нь ажилгүй болсон, 15.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна

## БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧДИЙН 2017, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

Зураг 42. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байсан эсэхээр


Хэмжих нэгж: хувь



2017 онд ажлын байрны боловсролын шаардлага нь эзэмшсэн боловсролоос нь доогуур хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 75.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 5.2 хувь нь ажлаасаа гарсан, 19.8 хувь нь эдийн засгийн идэвхгүй болсон. Мөн шаардлага нь тохирч байсан төгсөгчдийн 82.2 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хэвээр, 15.0 хувь нь эдийн засгийн идэвхгүй болсон байна.

Зураг 43. 2017 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах боловсролын түвшний шаардлагын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэхээр

Хэмжих нэгж: хувь



2017 онд ажлын байрны ур чадварын шаардлага нь эзэмшсэн ур чадвараас нь өндөр хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 78.3 хувь нь, ажлын байрны шаардлага эзэмшсэн ур чадвараас доогуур хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 73.6 хувь нь ажилтай хэвээр байна. Ажлын байрны ур чадварын шаардлага эзэмшсэн ур чадварт нь тохирсон ажил хийж байсан төгсөгчдийн 83.0 хувь нь ажилтай хэвээр, 2.9 хувь нь ажилгүй, 14.2 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжжээ.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 44. 2017 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах ур чадварын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэх


Хэмжих нэгж: хувь



### 5.3. 2017 ОНД АЖИЛГҮЙ БАЙСАН ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Төгссөнөөс нэг жилийн дараа буюу 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвх 2020 онд хэрхэн өөрчлөгдсөнийг тодруулахад ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн 66.1 хувь нь хөдөлмөр эрхэлж буй, 6.5 хувь нь ажилгүй, 27.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй байгаа бол ИДС төгсөгчдийн 68.7 хувь нь хөдөлмөр эрхэлж, 6.8 хувь нь ажилгүй, 24.5 хувь нь ЭЗИ-гүй байна. Ажилгүй байсан гурван төгсөгч тутмын хоёр нь ажилтай болжээ.

Зураг 45. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, сургуулийн төрлөөр



■ Хөдөлмөр эрхэлж буй   ■ Ажилгүй   ■ ЭЗИ-гүй

Тухайн онд ажилгүй байсан Улаанбаатарт байршилтай сургууль төгссөн төгсөгчдийн 71.8 хувь нь, орон нутагт байршилтай сургууль төгсөгчдийн 60.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Харин орон нутгийн сургууль төгссөн ажилгүй байсан төгсөгчдийн 9.3 хувь нь ажилгүй хэвээрээ, 30.1 хувь нь ЭЗИ-гүй буюу ажиллах хүчинээс гадуур байна.

Зураг 46. 2017 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, хүйсээр



2017 онд ажилгүй байсан эрэгтэй төгсөгчдийн 73.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа, 4.9 хувь нь ажилгүй хэвээрээ, 21.6 хувь нь ЭЗИ-гүй байна. Харин ажилгүй байсан эмэгтэй төгсөгчдийн 63.1 хувь нь хөдөлмөр эрхэлж, 7.9 хувь

нь ажилгүй хэвээрээ, 29.1 хувь нь ЭЗИ-гүй болсон байна.

Эзэмшсэн мэргэжилдээ огт сэтгэл хангалуун бус ажилгүй байсан төгсөгчдийн байсан төгсөгчдийн 14.0 хувь нь ажилгүй хэвээрээ, 16.2 хувь нь ЭЗИ-гүй буюу ажиллах хүчнээс гадуур байна.

2017 онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилтийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр харахад хамгийн их буюу 91.7 хувь нь ажилтай болсон нь тээврийн мэргэжлийн чиглэл эзэмшин ажилгүй байсан төгсөгчид. Харин барилга, архитектур, бүх төрлийн инженер, байгаль хамгаалал мэргэжлээр төгсөгчдийн 20.0-25.0 хувь нь ажилгүй хэвээрээ байна. Ажилгүйдлээс эдийн засгийн идэвхгүй байдал руу хамгийн ихээр шилжсэн нь багш, боловсрол судлал, хүмүүнлэгийн ухаан, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, анагаах ухааны чиглэлээр төгсөгчид байна

*Зураг 47. 2017 онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт*

Хэмжих нэгж. хувь



2017 онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн ЭЗИ-д ямар өөрчлөлт гарсныг мэргэжлийн чиглэлээр нь харахад эрчим хүчний салбарын мэргэжлээр төгсөгчдийн 94.2 хувь, тээвэр, барилга, уул уурхайн салбарын мэргэжлээр төгсөгчдийн 70.0 гаруй хувь хөдөлмөр эрхэлж байна. Харин байгаль орчин, аялал жуулчлал, боловсролын салбарын төгсөгчдийн хамгийн олон нь буюу 50-60 хувь нь ажилгүйгээс эдийн засгийн идэвхгүй байдалд шилжжээ. Харин боловсрол, үйлчилгээ, аж үйлдвэр, соёл урлагийн чиглэлээр төгсөгчид ажилгүй байсан бусад мэргэжлийн төгсөгчидтэй харьцуулахад эдийн засгийн идэвхийн төлөв нь өөрчлөгдөөгүй, ажилгүй хэвээрээ байна.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 48. 2017 онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт

Хэмжих нэгж. хувь



### 5.4. 2017, 2020 ОНД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВ, ӨӨРЧЛӨЛТ

2017, 2020 онд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн төлөв, хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн харилцааны өөрчлөлтийг энэ бүлэгт авч үзнэ.

2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 80 гаруй хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээрээ байгаа ч тухайн салбartaа тогтвортой ажиллаж чадаагүй байна. Судалгааны суурь он болох 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийг 2020 онд тухайн салбartaа хөдөлмөр эрхэлж байгаа эсэхийг сургуулийн төрлөөр тодруулахад ИДС төгсөгчдийн 49.6 хувь нь, МБСБ төгсөгчдийн 49.9 хувь нь тухайн салбartaа ажилласан хэвээр байна. Харин хөдөлмөр эрхэлж байсан хоёр төгсөгч тутмын нэг нь ажиллаж байсан салбараа өөрчилжээ.

Зураг 49. 2017 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх

Хэмжих нэгж: хувь



2017 онд хөдөлмөр эрхэлж байсан эрэгтэй төгсөгчдийн 46.1 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 53.6 хувь нь салбараа өөрчлөөгүй ажиллаж байна.

Байгууллагын өмчийн хэлбэрийн хувьд төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагад ажиллаж байсан төгсөгчдийн 68.9 хувь нь тухайн салбартаа хөдөлмөр эрхэлсэн хэвээр байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт. Мөн дотоод, гадаадын, хамтарсан хөрөнгө оруулалттай компанийд ажиллаж байсан төгсөгчдийн 57.2 хувь нь, төрийн өмчит үйлдвэрт 61.4 хувь нь ТББ, тусгай сан, нийгэмлэг, ОУБ-д ажиллаж байсан төгсөгчдийн 75.3 хувь нь ажиллаж байсан салбараа сольсон байна.

Хүснэгт 25. 2017 онд ажиллаж байсан салбар нь 2020 онд өөрчлөгдсөн эсэх, төгсөгчдийн зарим үзүүлэлтээр

Хэмжих нэгж: хувь

Төгсөгчдийн шинж байдал (2017)	2017 онд ажилласан салбараа өөрчилсөн эсэх		Бүгд
	Тийм	Үгүй	
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	46.1	53.9	100.0
Эмэгтэй	53.6	46.4	100.0
<b>Амьдарч байгаа бүс нутаг</b>			
Нийслэл	48.0	52.0	100.0
Баруун	55.3	44.7	100.0
Хангай	54.1	45.9	100.0
Төвийн	49.5	50.5	100.0
Зүүн	53.2	46.8	100.0
<b>ААНБ-ын төрөл</b>			
Дотоодын/гадаадын/хамтарсан хөрөнгө оруулалттай компани	42.8	57.2	100.0
Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллага	68.9	31.1	100.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	58.0	42.0	100.0
Төрийн өмчит үйлдвэр	38.6	61.4	100.0
ТББ, тусгай сан, нийгэмлэг, ОУБ, бусад	24.7	75.3	100.0

2017 онд төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагад ажиллаж байсан төгсөгчдийн 73.2 хувь нь, дотоод, гадаадын, хамтарсан хөрөнгө оруулалттай компанийд ажиллаж байсан төгсөгчдийн 73.5 хувь нь тухайн өмчийн хэлбэрийн байгууллагадаа ажиллаж байна. Харин ТББ, тусгай сан, нийгэмлэг, ОУБ-д ажиллаж байсан төгсөгчдийн 54.2 хувь нь дотоод, гадаадын, хамтарсан хөрөнгө оруулалттай компанийд, 33.3 хувь нь төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагад шилжин ажиллажээ.

Ажиллаж байсан ЭЗҮА-ны салбараа хамгийн өндөр хувиар өөрчилсөн нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, ХАА-н салбарт ажиллаж байсан төгсөгчид. Харин боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж, санхүү, даатгалын үйл ажиллагааны салбарт ажиллаж буй байсан төгсөгчид 70.0-78.0 хувь нь тухайн салбартаа ажилласан хэвээр байгаа нь ажиллаж байсан ЭЗҮА-ны салбараа хамгийн бага хувиар өөрчилсөн дүнтэй байгаа юм.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 50. 2017 онд ажиллаж байсан салбараа 2019 онд өөрчилсөн эсэх, ЭЗҮА-ны салбараар

Хэмжих нэгж: хувь

	Өөрчлөөгүй	Өөрчилсөн
Боловсрол	78.0	22.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн хalamж	72.4	27.6
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	70.4	29.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	67.5	32.5
ОУын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл...	67.4	32.6
Уул урхай, олборлолт	64.8	35.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	56.5	43.5
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл...	53.6	46.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	51.3	48.7
Ус хангамж, бохир зайлцуулах систем, хог...	48.0	52.0
Барилга	47.1	52.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	41.0	59.0
Мэдээлэл, холбоо	37.9	62.1
Боловсруулах үйлдвэрлэл	36.3	63.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин...	30.8	69.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	25.9	74.1
ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	25.3	74.7
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны...	22.3	77.7
Мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл...	11.3	88.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл...	10.7	89.3

2017, 2020 оны цалинг харьцуулахад төгсөгчдийн 5.9 хувийн цалин хэвээр байгаа бол 81.4 хувьд нь өссөн, 13.7 хувьд нь буурсан үзүүлэлттэй байна. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 12.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 13.7 хувь нь цалин буурсан гэжээ.

Зураг 51. 2017 оноос цалин, орлого нь өөрчлөгдсөн байдал, сургуулийн төрөл, хувиар




Төгсөгчдийн 2017, 2020 оны цалинг хүйсээр харахад эрэгтэй төгсөгчдийн 6.1 хувьд нь, эмэгтэй төгсөгчдийн 5.7 хувьд нь цалин хэвээрээ байна. Мөн авч байсан цалингийн өөрчлөлтийг байршилаар нь харахад Улаанбаатарт оршин суугаа буй төгсөгчдийн 82.9 хувь нь цалин өссөн бол зүүн бүсийн төгсөгчдийн 21.6 хувийн цалин нь буурсан гэж хариулсан бусадтайгаа харьцуулахад өндөр үзүүлэлт байна.

2017, 2020 онд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 54.6 хувь нь мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 19.9 хувь нь мэргэжлийн бус ажил хийсэн хэвээр, 10.9 хувь нь мэргэжлийн ажилд шилжсэн бол 14.6 хувь нь мэргэжлийн бус ажил эрхлэх болсон байна. Энэ үзүүлэлтийг сургуулийн төрлөөр нь харвал МБСБ төгсөгчдийн 44.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлсэн хэвээрээ, 29.7 хувь нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 17.9 хувь нь мэргэжлийн ажлаас мэргэжлийн бус ажил руу шилжсэн байна. Харин ИДС төгсөгчдийн 58.9 хувь нь мэргэжлийн ажил хийсэн хэвээр байгаа бол 15.7 хувь нь мэргэжлийн бус ажил хийдэг хэвээр, 13.3 хувь нь мэргэжлийн бус ажил руу шилжжээ.

*Зураг 52. Мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэх байдалд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр*

Хэмжих нэгж: хувь



Эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлтийг хүйсээр гаргахад эрэгтэй төгсөгчдийн 54.1 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 55.1 хувь мэргэжлийн дагуу ажил хийдэг хэвээр харин эрэгтэй төгсөгчдийн 21.7 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 17.9 хувь нь мэргэжлийн бус ажил хийсээр байна. Мөн эмэгтэй төгсөгчдийн 13.8 хувь нь мэргэжлийн ажлаас мэргэжлийн бус ажил руу шилжжээ.


Эрхэлж буй ажил, эзэмшсэн мэргэжлийн нийцлийн 2017, 2020 онд гарсан өөрчлөлтийн хувьд ИДС-ийг малэмнэлэг, урлаг, анагаах ухаан, барилга, архитектур, багш, боловсрол судлал зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 73.4-F хувь нь мэргэжлийн дагуу ажилласан хэвээр байгаа бол байгаль хамгаалал, ХАА, нийгэм, эдийн засаг, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, биологи мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн дунд мэргэжлийн бус ажил хийх нь харьцангуй түгээмэл хэвээр байна.

Мэргэжлийн бус ажил руу шилжин ажиллах байдал биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, хүмүүнлэгийн ухаан, нийгмийн халамж, хангамж, ХАА-н мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн дунд түгээмэл байна.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 53. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2017, 2020 онд гарсан өөрчлөлт, ИДС-н мэргэжлийн чиглэлээр


Хэмжих нэгж: хувь



МБСБ-ын хувьд эрүүл мэндийн салбарын мэргэжлээр төгсөгчдийн 79.5 хувь нь, эрчим хүчний салбарын мэргэжлээр төгсөгчдийн 78.9 хувь нь эзэмшсэн мэргэжлийн дагуу ажилладаг хувеэр байгаа нь бусад мэргэжлийн төгсөгчидтэй харьцуулахад өндөр байна. Боловсрол, соёл урлаг, барилга, ХАА, мэдээллийн технологи салбарын мэргэжлээр төгсөгчдийн 40.0-50.0 хувь нь мэргэжлийн бус ажил хийсэн хувеэр байна. Харин санхүү, бизнес, худалдааны, боловсрол, мэдээллийн технологи, тээвэр, уул уурхай, аж үйлдвэрийн салбарын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид мэргэжлийн бус ажил руу илүү шилжжээ.

## БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧДИЙН 2017, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

**Зураг 54. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2017, 2019 онд гарсан өөрчлөлт, МБСБ-ын мэргэжлийн чиглэл, хувиар**



2017, 2020 онд хөдөлмөр эрхэлж байсан ИДС төгсөгчдийн 81.3 хувь нь, МБСБ төгсөгчдийн 66.7 хувь нь гэрээ байгуулан хөдөлмөр эрхэлсэн хэвээр байна. МБСБ төгсөгчдийн 12.0 хувь нь гэрээгүй ажиллаж байгаа бол, 6.7 хувь нь гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаад гэрээгүй ажиллах болжээ. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 92.6 хувь нь гэрээгээр ажилласан хэвээр, 7.4 хувь нь гэрээтэй төлөвөөс гэрээгүй төлөвт шилжсэн байна. Харин гэрээгүй ажиллаж байсан төгсөгчдийн 26.3 хувь нь гэрээгүй хэвээр, 73.7 хувь нь гэрээгүй төлөвөөс гэрээтэй төлөв рүү шилжсэн байна.

**Хүснэгт 26. 2017, 2020 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар**

Гэрээ байгуулан ажиллаж байгаа эсэх	2020 он					Бүгд
	Гэрээтэй ажилласан хэвээр	Гэрээгүй ажилласан хэвээр	Гэрээгүй толовоос гэрээтэй толов рүү шилжсэн	Гэрээтэй толовоос гэрээгүй толов рүү шилжсэн		
2017 он	Гэрээтэй	92.6	0.0	0.0	7.4	100.0
	Гэрээгүй	0.0	26.3	73.7	0.0	100.0



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

VI

БҮЛЭГ

ТӨГСӨГЧДИЙН  
2019, 2020 ОНЫ  
ХӨДӨЛМӨРИЙН  
ЗАХ ЗЭЭЛ ДЭХ  
ХӨДӨЛГӨӨН

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн 2 жилийн өөрчлөлтийг харуулна. Сүүлийн 2 жилийн хугацаанд эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлт хөдөлгөөн, 2019 онд ажилтай байсан төгсөгчдийн ЭЗИ-д нэг жилийн дараа гарсан өөрчлөлт, 2019, 2020 онд хоёуланд нь хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн салбар, ажил, мэргэжил, цалин зэргийн өөрчлөлтийг харуулах юм.

## 6.1. НИЙТ ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Тайлангийн энэ хэсэгт төгсөгчдийн сүүлийн 2 жилийн хугацааны эдийн засгийн идэвх, түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулахыг зорилоо. Өөрөөр хэлбэл хоёр жилийн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд гарсан нийт өөрчлөлт, хөдөлгөөнийг бүхэлд нь, өсөн нэмэгдсэн дүнгээр харуулах юм.

2019 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 76.5 хувь байсан бол 2020 онд 74.8 хувь болж 1.7 пункттээр буурсан. Үүнийг сургуулийн төрлөөр нь үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин ИДС төгсөгчдийн хувьд 2.6 пункттээр, МБСБ төгсөгчдийн хувьд 0.1 пункттээр буурчээ. Мөн өмнөх оноос ИДС төгсөгчдийн ажилгүйдэл 1.5 пункттээр өссөн бол МБСБ төгсөгчдийн хувьд өөрчлөлт гараагүй.

Харин өмнөх онд ажилгүй өсвэл эдийн засгийн идэвхгүй байсан ИДС төгсөгчдийн 8.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 13.1 хувь нь ажилтай болсон. Мөн ИДС төгсөгчдийн 20.1 хувь, МБСБ төгсөгчдийн 25.4 хувь нь ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон буюу судалгааны сүүлийн хоёр жилийн аль нэгэнд нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Сүүлийн хоёр онд төгсөгчдийн 87.0 хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцож хөдөлмөр эрхэлсэн байна. Нарийвчилбал, ИДС төгсөгчдийн 88.6 хувь, МБСБ төгсөгчдийн 84.4 хувь нь тогтвортой хөдөлмөр эрхэлж ажлын туршлагаа нэмэгдүүлжээ. Харин ИДС төгсөгчдийн 5.6 хувь нь, МБСБ төгсөгчдийн 9.2 хувь нь сүүлийн хоёр жилийн судалгааны аль нэгэнд нь ажилгүй, мөн ИДС төгсөгчдийн 28.3 хувь нь, МБСБ төгсөгчдийн 36.5 хувь нь хоёр жилийн аль нэг хугацаанд эдийн засгийн идэвхгүй төлөвт байжээ.

**Хүснэгт 27. Нийт төгсөгчдийн эдийн засгийн идэвх, 2019, 2020 он, сургуулийн төрлөөр**

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Сургуулийн төрөл		Нийт
	ИДС	МБСБ	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Ажил эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2019	79.5	71.6	76.5
Ажил эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	76.9	71.5	74.8
Ажил эрхлэлтийн цэвэр өөрчлөлт, %, 2019-2020	-2.6	-0.1	-1.7
Үүнд: 2020 онд ажилтай болсон хувь	8.8	13.1	10.4
2020 онд ажлаас гарсан хувь	11.3	12.3	11.7
Ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон нийт төгсөгчдийн хувь, %, 2019-2020	20.1	25.4	22.2
Ажил эрхлэлтийн бохир түвшин, 2019-2020	88.6	84.4	87.0

**Ажилгүйдэл**

## БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

Ажилгүй төгсөгчдийн эзлэх хувь, 2019	2.5	5.2	3.6
Ажилгүй төгсөгчдийн эзлэх хувь, 2020	4.0	5.2	4.5
Ажилгүйдлийн түвшний цэвэр өөрчлөлт, % 2019-2020	1.5	0.0	0.9
Үүнд: 2019 оноос хойш шинээр ажилгүй болсон хувь	3.6	4.3	3.9
2019 оноос хойш ажилгүйдлийн гарсан хувь	1.8	4.1	2.7
Ажилгүйдлийн бохир түвшин, %, 2019-2020	5.6	9.2	7.0
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2019	17.9	23.1	19.9
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2020	19.1	23.3	20.7
Эдийн засгийн идэвхгүй түвшний цэвэр өөрчлөлт, % 2019-2020	1.2	0.2	0.8
Үүнд: 2019 оноос хойш шинээр эз-ийн идэвхгүй болсон %	10.1	12.7	11.1
2019 оноос хойш эз-ийн идэвхгүй байдлаас гарсан %	9.3	13.7	11.0
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн бохир түвшин, 2019-2020	28.3	36.5	31.4

Сүүлийн 2 жилд төгсөгчдийн 74.6 хувь нь эдийн засгийн идэвхээ өөрчлөөгүй бөгөөд сургуулийн төрлөөр ангилан харахад ИДС төгсөгчдийн 77.5 хувь, МБСБ төгсөгчдийн 69.6 хувь нь байна. Эдийн засгийн идэвхийн төлөв нь өөрчлөгдөөгүй төгсөгчдийг нарийвчлан авч үзвэл ИДС төгсөгчдийн 68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж, 0.2 хувь нь ажилгүй 8.9 хувь нь ажиллах хүчинээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй, МБСБ төгсөгчдийн 58.9 хувь нь хөдөлмөр эрхэлж, 0.8 хувь нь ажилгүй, 10.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй хэвээр буюу төлөв нь өөрчлөгдөөгүй байна. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн өөрчлөлт, хөдөлгөөнүүд төгсөгчдийн хувьд хэр өргөн хүрээг хамарсан байгааг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

**Хүснэгт 28. Эдийн засгийн идэвхэд шилжилт хийсэн байдал, сургуулийн төрлөөр  
Хэмжих нэгж: хувь**

Төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд 2019, 2020 онд гарсан хөдөлгөөнүүд	Сургуулийн төрөл		Нийт
	ИДС	МБСБ	
<b>Эдийн засгийн идэвх нь өөрчлөгдөөгүй</b>	<b>77.5</b>	<b>69.9</b>	<b>74.6</b>
Хөдөлмөр эрхэлдэг эрхэлдэг хэвээр	68.4	58.9	64.8
Ажилгүй хэвээр	0.2	0.8	0.4
Эдийн засгийн идэвхгүй хэвээр	8.9	10.1	9.4
<b>Эдийн засгийн идэвхэд эерэг өөрчлөлт гарсан</b>	<b>10.5</b>	<b>15.7</b>	<b>12.5</b>
Эдийн засгийн идэвхгүйгээс ажилгүйд шилжсэн	1.7	2.6	2.0
Эдийн засгийн идэвхгүйгээс хөдөлмөр эрхэлдэгт шилжсэн	7.6	11.1	9.0
Ажилгүйгээс хөдөлмөр эрхэлдэгт шилжсэн	1.2	2.0	1.5
<b>Эдийн засгийн идэвхэд сөрөг өөрчлөлт гарсан</b>	<b>12.0</b>	<b>14.5</b>	<b>12.9</b>
Хөдөлмөр эрхэлдгээс ажилгүй төлөвт шилжсэн	1.9	1.7	1.8
Хөдөлмөр эрхэлдгээс эдийн засгийн идэвхгүйд шилжсэн	9.4	10.6	9.9
Ажилгүйгээс эдийн засгийн идэвхгүйд шилжсэн	0.6	2.1	1.2
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Өмнөх онтой харьцуулахад эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 7.4 пунктээр нэмэгдсэн бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 5.5 пунктээр буурчээ. Хөдөлмөр эрхлэлтийн бохир түвшинг хүйсээр харахад эрэгтэй төгсөгчдийн 95.1 хувь нь,

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

эмэгтэй төгсөгчдийн 81.2 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд эсвэл аль нэг жилд нь хөдөлмөр эрхэлжээ. Мөн эмэгтэйчүүдийн 8.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 4.6 хувь нь сүүлийн хоёр жилийн хугацаанд эсвэл аль нэгэнд нь ажилгүй байжээ. Ажиллах хүчнээс гадуур байгаа эрэгтэйчүүд 7.5 пунктээр буурсан, эмэгтэйчүүд 5.1 пунктээр нэмэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх буурсан байна.

Хүснэгт 29. Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн шилжилт, 2019, 2020 он, хүйсээр

Хэмжих нэгж: хувь

Эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүд	Хувь		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Хөдөлмөр эрхлэлт</b>			
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2019	79.5	71.6	76.5
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр түвшин, %, 2020	86.9	66.1	74.8
Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр өөрчлөлт, %, 2019-2020	7.4	-5.5	-1.7
Үүнд: 2020 онд ажилтай болсон хувь	7.2	12.7	10.4
2020 онд ажлаас гарсан хувь	6.8	15.2	11.7
Ажлын байрны дахин хуваарилалтад оролцсон нийт төгсөгчдийн хувь, %, 2019-2020	14.0	27.9	22.2
Хөдөлмөр эрхлэлтийн бохир түвшин, 2019-2020	95.1	81.2	87.0
<b>Ажилгүйдэл</b>			
Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2019	2.5	5.2	3.6
Ажилгүйдлийн цэвэр түвшин, 2020	2.7	5.7	4.5
Ажилгүйдлийн түвшний цэвэр өөрчлөлт, % 2019-2020	0.2	0.5	0.9
Үүнд: 2019 оноос хойш шинээр ажилгүй болсон хувь	2.2	5.1	3.9
2019 оноос хойш ажилгүйдлээс гарсан хувь	1.9	3.2	2.7
Ажилгүйдлийн бохир түвшин, %, 2019-2020	4.6	8.7	7.0
<b>Эдийн засгийн идэвхгүй</b>			
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2019	17.9	23.1	19.9
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн цэвэр түвшин, 2020	10.4	28.2	20.7
Эдийн засгийн идэвхгүй түвшний цэвэр өөрчлөлт, % 2019-2020	-7.5	5.1	0.8
Үүнд: 2019 оноос хойш шинээр эз-ийн идэвхгүй болсон %	6.4	14.4	11.1
2019 оноос хойш эз-ийн идэвхгүй байдлаас гарсан %	7.2	13.7	11.0
Эдийн засгийн идэвхгүй төгсөгчдийн бохир түвшин, 2019-2020	16.2	42.2	31.4

### 6.2. 2019 ОНД АЖИЛТАЙ БАЙСАН ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 84.7 хувь нь 2020 онд хөдөлмөрийн зах зээлд тогтвортой хөдөлмөр эрхэлсэн хэвээр байна. Харин 2.4 хувь нь ажилгүй, 12.9 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжжээ. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 85.8 хувь нь МБСБ төгсөгчдийн 82.7 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр байна. Харин 14.2-17.3 хувь нь ажлаасаа гарсан байна.

## БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

**Зураг 55. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, хувиар**



ЭЗҮА-ны салбараар 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхэд гарсан өөрчлөлтийг харахад ус хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, ОУБ, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчид 100.0 хувь тухайн салбарт ажилласан хэвээр байна.

Харин боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчийн дунд ажлаасаа гарсан төгсөгчид олон байна. Мөн мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа салбарт хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 26.4 хувь нь, ХАА-н салбарт хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 24.9 хувь нь, үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 21.0 хувь нь эдийн засгийн идэвхгүй болжээ.

**Хүснэгт 30. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар**

Хэмжих нэгж: хувь

2019 онд ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2020 оны ЭЗИ-ийн төлөв			Бүгд
	Ажилтай хэвээр	Ажилгүй болсон	ЭЗИ-гүй болсон	
Ус хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	100.0	0.0	0.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	100.0	0.0	0.0	100.0
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	100.0	0.0	0.0	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	98.7	0.0	1.3	100.0
Мэдээлэл, холбоо	93.9	0.5	5.7	100.0
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	90.4	0.1	9.5	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	90.3	2.6	7.1	100.0
Үул уурхай, олборлолт	90.1	2.3	7.7	100.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн хalamж	87.0	1.3	11.7	100.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	86.4	0.3	13.3	100.0
Барилга	84.0	3.4	12.6	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	83.2	2.9	13.9	100.0
Боловсрол	83.2	0.3	16.5	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	81.0	5.1	13.9	100.0
Урлаг, узвэр, тоглоом наадам	80.1	4.7	15.2	100.0

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	79.5	6.6	13.9	100.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	78.6	6.7	14.7	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	76.9	2.0	21.0	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа	73.6	0.0	26.4	100.0
ХАА, ойн аж ахуй, загас, ан агуулур	72.0	3.2	24.9	100.0
<b>Бүгд</b>	<b>84.7</b>	<b>2.4</b>	<b>12.9</b>	<b>100.0</b>

Төгсөгчдийг 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь харахад төрийн өмчтэй үйлдвэрийн газарт ажиллаж байсан төгсөгчдийн 94.4 хувь нь ажилтай хэвээр, харин хувиараа хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 3.0 хувь нь ажилгүй, 19.6 хувь нь эдийн засгийн идэвхгүй болжээ.

2019 онд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 87.3 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 2.0 хувь нь ажилгүй болсон, 10.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжсэн байна. Харин мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 77.8 хувь нь ажилтай хэвээр, 3.4 хувь нь ажилгүй болсон бол, 18.8 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөв рүү шилжжээ.

Зураг 56. 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байсан эсэхээр




Төгсөгчдийн 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан ажлын байрны боловсролын шаардлага нь эзэмшсэн боловсролоос нь доогуур байсан төгсөгчдийн 78.8 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 3.1 хувь нь ажлаасаа гарсан, 18.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй болсон. Мөн шаардлага нь тохирч байсан төгсөгчдийн 85.4 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хэвээр, 2.2 хувь нь ажилгүй, 12.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй болжээ. Харин ажлын байрны боловсролын шаардлага нь эзэмшсэн боловсролоос нь өндөр байсан төгсөгчдийн 2.9 хувь нь ажилгүй байна.

## БУЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

Зураг 57. 2019 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн ЭЗИ-ийн өөрчлөлт, эзэмшсэн ба ажлын байранд шаардах боловсролын түвшний шаардлагын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэхээр

Хэмжих нэгж: хувь



Төгсөгчдийн 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан ажлын байраны ур чадварын шаардлага нь эзэмшсэн ур чадвараас нь доогуур гэж үзсэн төгсөгчдийн 74.3 хувь нь ажилтай хэвээр байгаа бол 4.5 хувь нь ажилгүй, 21.2 хувь нь эдийн засгийн идэвхгүй болжээ. Харин ажлын байраны шаардлага эзэмшсэн ур чадвараас нь өндөр байсан төгсөгчдийн 87.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр байна.

Зураг 58. 2019 оны хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшсэн ба ажлын байранд шаардах ур чадварын нийцэл ЭЗИ-д нөлөөлсөн эсэх

Хэмжих нэгж: хувь



2019 онд хөдөлмөр эрхэлж байсан байгууллагынхаа ХАБЭА-даа огт сэтгэл ханамжгүй байсан төгсөгчдийн 63.8 ажилтай хэвээрээ, 3.6 хувь нь ажилгүй, 32.7 хувь нь ажиллах хүчинээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжжээ.

### 6.3. 2019 ОНД АЖИЛГҮЙ БАЙСАН ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн 47.4 хувь нь хөдөлмөр эрхэлж, 14.1 хувь нь ажилгүй хэвээрээ, 38.6 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна. Хөдөлмөр эрхлээгүй байсан ИДС төгсөгчдийн 58.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 40.1 хувь нь ажилтай болсон бол ИДС төгсөгчдийн 9.6 хувь нь, МБСБ төгсөгчдийн 17.0 хувь нь ажилгүй хэвээрээ байна.

Зураг 59. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, сургалтын төрлөөр

Хэмжих нэгж: хувь



Харин хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн 41.6 хувь нь ажилд орсон, 19.4 хувь нь ажилгүй хэвээрээ, 39.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй буюу ажиллах хүчинээс гадуур байна. Харин эмэгтэйчүүдийн 50.0 ажилтай болж, 11.6 хувь нь ажилгүй хэвээрээ, 38.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй болжээ.

Зураг 60. 2019 онд ажилгүй байсан төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, амьдарч байсан байршилаар

Хэмжих нэгж: хувь

2019 онд ажилгүй байсан төгсөгчдийг бүсээр нь хараад Улаанбаатарт оршин сууж байсан төгсөгчдийн 57.4 хувь нь хөдөлмөр эрхэлж, 20.4 хувь нь ажилгүй хэвээрээ, 22.2 хувь нь ЭЗИ-гүй болжээ. Харин баруун бүсийн хувьд өмнөх онд ажилгүй байсан төгсөгчдийн 23.5 хувь нь ажилд орсон бол 28.4 хувь нь ажилгүй хэвээрээ байна.



Өмнөх онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилтийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр нь хараад мэдээлэл, сэтгүүл зүй, бизнес удирдлага, физик, хими, геологи, газар зүй, математик, статистик, үйлдвэрлэлийн технологи, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, байгаль хамгаалал зэрэг мэргэжлийн чиглэл эзэмшин ажилгүй байсан төгсөгчдийн бүгд (100%) 2020 онд хөдөлмөр эрхэлж буй нь бусад мэргэжлийн төгсөгчдөөс өндөр байна.

Харин барилга, архитектур мэргэжлийн чиглэл эзэмшин ажилгүй байсан төгсөгчид бүгд, хүмүүнлэгийн ухаан мэргэжлээр төгсөгчдийн 33.3 хувь нь ажилгүй хэвээрээ байна. Мөн багш, боловсрол судлал, хууль, эрх зүй, мал эмнэлэг, анагаах ухаан, тээвэр зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчид бусад мэргэжлийн чиглэлээр төгсөгчдөөсөө илүү ЭЗИ-гүй байдал руу шилжжээ.

Зураг 61. 2019 онд ажилгүй байсан ИДС төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



Өмнөх онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн шилжилтийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр нь хараад эрчим хүчиний мэргэжил эзэмшсэн төгсөгчид 100.0 хувь, уул уурхайн мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн 92.1 хувь нь, байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн 79.6 хувь нь санхүү, бизнес, худалдааны мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн 73.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа буюу ажилгүйдлээс гарсан байна. Харин үйлчилгээний салбарын ажилгүй байсан төгсөгчдийн 71.4 хувь нь, ХААН салбарын ажилгүй байсан төгсөгчдийн 23.0 хувь нь ажилгүй ажилгүй хэвээрээ байна. Дэлгэрэнгүйг дараах зургаас харна уу.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 62. 2019 онд ажилгүй байсан МБСБ төгсөгчдийн ЭЗИ-ийн шилжилт, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь



### 6.4 СҮҮЛИЙН ХОЁР ЖИЛИЙН ХУГАЦААНД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Энэ хэсэгт сүүлийн хоёр жилд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлийн шилжилтийг харуулахыг зорилоо.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ажиллаж байгаа салбараа өөрчилсөн эсэхийг тодруулахад 60.5 хувь нь тухайн салбартай ажиллаж байгаа бол 39.5 хувь нь салбараа өөрчилжээ. Тэдгээрийн сургуулийн төрлөөр нь харахад ИДС төгсөгчдийн 62.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 57.3 хувь нь тухайн салбартай ажилласан хэвээр байгаа бол ИДС төгсөгчдийн 37.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 42.7 хувь нь өөр салбарт ажиллаж байна.

Зураг 63. 2019 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх

Хэмжих нэгж: хувь



2019 онд ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбараа, эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь, эмэгтэйчүүдийн 63.9 хувь нь өөрчилсөн байна. Байршлын хувьд Улаанбаатарт оршин сууж байсан төгсөгчдийн 59.9 хувь нь, баруун бүсийн төгсөгчдийн 64.7 хувь нь 2019 онд ажиллаж байсан салбараа өөрчилжээ.

## БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

Харин 2019 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн ЭЗҮА-ны салбар тус бүрийн шилжилт хөдөлгөөнийг хараад санхүү болон даатгалын үйл ажиллагаа, төрийн удирдлага, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж, ус хангамж, бохир зайлцуулах систем, хог хаягдлын менежмент, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчид тухайн салбartaа 70-с дээш хувь нь салбараа өөрчлөөгүй харьцангуй тогтвортой ажиллаж байна. Харин удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 97.6 хувь нь, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 76.3 хувь нь ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 73.0 хувь нь, урлаг, үзвэр, тоглоом наадмын үйл ажиллагааны салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 71.6 хувь нь ажиллаж байсан

*Зураг 64. 2019 онд ажиллаж байсан салбараа 2020 онд өөрчилсөн эсэх, ЭЗҮА-ны салбараар*

Хэмжих нэгж: хувь



Мөн төгсөгчдийн салбар хоорондын шилжих хөдөлгөөнийг хараад боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 16.2 хувь нь худалдаа, 13.3 хувь нь үйлчилгээний салбар руу шилжин ажиллажээ. Бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 21.9 хувь нь үйлчилгээний, 9.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллаж байсан төгсөгчдийн 14.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 30.6 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Харин ОУБ, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхэлж

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

байсан төгсөгчдийн 25.1 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны, 31.2 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт шилжин ажиллаж байна. Салбар хоорондын шилжих хөдөлгөөнийг харахад үйлчилгээний салбарт илүү шилжиж ажиллаж байгаа нь харагдаж байгаа юм. Энэ нь түр ажлын байр олноор бий болдог, ажлын байрны шаардлага бага байдагтай холбоотой байж болно.

Мөн төгсөгчдийн 2019 онд авч байсан цалинг 2020 оны цалинтай харьцуулахад 15.9 хувь нь цалин хэвээр байгаа гэсэн бол 57.5 хувь нь өссөн, 26.6 хувь нь цалин буурсан гэжээ. Харин сургуулийн төрлөөр нь харахад ИДС төгсөгчдийн 57.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 56.8 хувь нь цалин нь өссөн бол төгсөгчдийн 20 гаруй хувийнх нь цалин буурчээ.

Зураг 65. 2019 оноос хойш цалин, орлого нь өөрчлөгдсөн байдал, сургуулийн төрөл, хувиар




2019, 2020 онд хөдөлмөр эрхэлж байсан эмэгтэй төгсөгчдийн 16.9 хувь нь цалин хэвээр, 58.6 хувь нь өссөн, 24.5 хувь нь цалин нь буурсан гэжээ.

Мөн авч байсан цалингийн өөрчлөлтийг байршилаар нь харахад Улаанбаатар оршин сууж байсан төгсөгчдийн 56.6 хувь нь, хангайн бүсэд амьдарч байсан төгсөгчдийн 64.2 хувь нь, төвийн бүсэд амьдарч байсан төгсөгчдийн 63.2 хувь нь цалин өссөн гэсэн бол, цалин нь хамгийн ихээр буурсан бус нь зүүн, баруун бүсэд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид байна.

МБСБ төгсөгчдийн 47.2 хувь нь, ИДС төгсөгчдийн 63.0 хувь нь эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу хөдөлмөр эрхэлсэн хэвээр, МБСБ төгсөгчдийн 23.7 хувь нь, ИДС төгсөгчдийн 14.8 хувь нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлсээр байгаагаа илэрхийлжээ.

Зураг 66. Мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, сургуулийн төрлөөр



Сүүлийн 2 жилд эмэгтэй төгсөгчдийн 59.3 хувь, эрэгтэй төгсөгчдийн 56.0 хувь нь мэргэжлийн дагуу ажил эрхэлсэн хэвээр байна. Хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй төгсөгчдийн 20.1 хувь нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 5.4


## БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧДИЙН 2019, 2020 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХӨДӨЛГӨӨН

хувь нь мэргэжлийн бус ажлаас мэргэжлийн ажил руу шилжсэн бол, 18.5 хувь нь мэргэжлийн ажлаас мэргэжлийн бус ажил хийх болжээ.

Сүүлийн хоёр жилийн мэргэжлийн дагуу ажиллах байдлыг тодруулахад анагаах ухаан, мал эмнэлэг, барилга, архитектур, багш, боловсрол судлал, урлаг зэрэг мэргэжлээр төгсөгчид бусад мэргэжлийн чиглэлээр төгсөгчдөөсөө илүү мэргэжлийн ажлаа хийсэн хэвээр байна.

Хамгийн олноор мэргэжлийн бус ажил эрхэлсэн хэвээр байгаа нь ХАА, нийгмийн халамж, хангамж, байгаль хамгаалал, биологи мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байна. Мөн бусдаасаа илүү мэргэжлийн бус ажил руу шилжсэн нь биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ, хүмүүнлэгийн ухаан, нийгэм, эдийн засаг мэргэжлээр төгсөгчид байна.

**Зураг 67. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2019, 2020 онд гарсан өөрчлөлт, ИДС-ийн мэргэжлийн чиглэлээр**




Сүүлийн хоёр жилд эрүүл мэндийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 86.0 хувь нь, эрчим хүчний мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 72.0 хувь нь 2 жилийн хугацаанд мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлсэн байна. Харин боловсрол, барилга, мэдээллийн технологи, байгаль орчин, ХАА-н мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэх байдал харьцангуй өндөр байна.

2019 онд ХАА, санхүү, бизнес, худалдаа, байгаль орчны мэргэжлийн чиглэлээр төгсөгчид мэргэжлийн бус ажлаас мэргэжлийн ажил руу хамгийн их шилжсэн бол, соёл урлаг, санхүү, бизнес, худалдаа, мэдээллийн технологи, аж үйлдвэрийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчид мэргэжлийн ажлаас гарч мэргэжлийн бус ажил руу илүү шилжсэн байна.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2020

Зураг 68. Ажил ба мэргэжлийн нийцлийн 2019-2020 онд гарсан өөрчлөлт, МБСБ-ын мэргэжлийн чиглэлээр

Хэмжих нэгж: хувь




2019 онд гэрээтэй ажиллаж байсан төгсөгчдийн 92.3 хувь нь гэрээтэй ажилласан хэвээр байгаа бол 7.7 хувь нь гэрээгүй ажиллах болсон байна. Гэрээгүй ажиллаж байсан төгсөгчдийн 44.4 хувь нь гэрээгүй ажилласан хэвээр, 56.0 хувь нь гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 31. 2019, 2020 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар

Гэрээ байгуулан ажиллаж байгаа эсэх	2020 он					Бүгд
	Гэрээтэй ажилласан хэвээр	Гэрээгүй ажилласан хэвээр	Гэрээгүй төлвөөс гэрээтэй төлөв рүү шилжсэн	Гэрээтэй төлвөөс гэрээгүй төлөв рүү шилжсэн		
2019 он	Гэрээтэй	92.3	0.0	0.0	7.7	100.0
	Гэрээгүй	0.0	44.0	56.0	0.0	100.0

МБСБ төгсөгчдийн 67.6 хувь нь, ИДС төгсөгчдийн 87.4 хувь нь гэрээгээр ажилласан хэвээр байна. Харин МБСБ төгсөгчдийн 14.2 хувь нь гэрээгүй, 8.2 хувь нь гэрээтэй ажиллаж байгаад гэрээгүй ажиллах болжээ.

Зураг 69. 2018, 2019 онд цалин хөлстэй ажиллах байдалд гарсан өөрчлөлт, хувиар



## ДҮГНЭЛТ

- ✓ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь 2015-2016 онд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг дүүргэн, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдсэн ажиллах хүчний талаар судалсан, панел судалгааг 4 жилийн хугацаанд явууллаа. Энэ удаагийн судалгааны тайлан нь төгсөгчдийн мэргэжил эзэмшсэнээс хойш 48 сарын хугацааг агуулсан, Х33 дэх 2020 оны төлөв, 2017-2020 оны хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг харьцуулан харах боломжийг олгож буйгаараа онцлог юм.
- ✓ Өмнөх онтой харьцуулахад төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 1.7 пунктээр буурчээ. Ажиллах хүчнээс гадуурх буюу эдийн засгийн идэвхгүй байгаа таван төгсөгч тутмын хоёр нь цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг сонирхож буй боломжит ажиллах хүч байна. Нийт боломжит ажиллах хүчний 4.1 хувь нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байгаа, ур чадварт тохиорох ажил байхгүй, туршлага байхгүй, ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу гэж үздэгийн улмаас итгэл алдарсан төгсөгчид байна.
- ✓ Эмэгтэй төгсөгчдийн хувьд хөдөлмөр эрхлэлт бага, эдийн засгийн идэвхгүй байгаа нь нөхөн үржихүйн насын онцлогоос хамаарч, хүүхэд төрүүлэх, асрах шалтгааны улмаас эдийн засгийн үйл ажиллагааны оролцоонд тодорхой хязгаарлалтууд үүсдэг болохыг ялгаж ойлгох зүйтэй юм.
- ✓ Төгсөгчид хөдөлмөр эрхэлж байгаа нь чухал хэдий ч тэд сургуульд суралцаж эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг тандан, судлах хэрэгтэй. Тодорхой цаг хугацаа, хөрөнгө зарцуулан эзэмшсэн мэргэжилтэйгээ тохиорохгүй өөр чиглэлийн ажил хийх байдал МБСБ төгссөн хоёр төгсөгч тутмын нэгд нь, ИДС төгссөн арван төгсөгч тутмын гуравд тохиолдож байгаа нь анхаарахгүй орхиж болохгүй үзүүлэлт юм.
